Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
4 дүгээр хавсралт

# ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ**<br>**1. "КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛЫН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ**<br>***Стратеги төлөвлөгөөний зорилго 1.1 "Ковид-19" болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг 92 хувьд хүргэнэ.*** | | | | | | | |
| 1 | Зорилт 1.1.1 Хүний нөөц,техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллана. | | | | | | |
| 2 | Арга хэмжээ 1.1.1.1. Сумын Онцгой комисс, Шуурхай штабын бүрэлдэхүүнд тодотгол хийнэ. | - | Тодотгосон албан хаагчийн тоо | - | Сумын Засаг даргын захирамжаар шинэчлэн томилсон байна. | Аймгийн Засаг даргын нэрэмжит Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулагдах удирдамжийн хүрээнд сумын Засаг даргын 2024 оны 04 сарын А/191 дүгээр захирамжаар сумын Онцгой комисс, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд тодотгол хийж баталсан. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд захирамжаар томилогдсон боловч өөр ажилд шилжсэн, эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлт өгсөн, ажлаас өөрийн хүсэлтээр болон өндөр насны тэтгэвэр тогтоолгож гарсан нийт 10 албан хаагчийн оронд тодотгол хийж мэргэжлиййн ангийн бие бүрэлдэхүүнийг 66 орон тоотойгоор баталсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Зорилт 1.1.2. Халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгаа, тандалт сэргийлэлтийн ажлыг зохион байгуулна. | | | | | | |
| 4 | Арга хэмжээ 1.1.2.1 Мэдээллийн хэрэгслээр урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл хүргэнэ. | - | Мэдээлэл хүргэсэн иргэдийн тоо, хүргэсэн мэдээллийн тоо | 2022 онд 40 мэдээлэл хүргэсэн. | Улиралд нэгээс доошгүй мэдээлэл хүргэнэ. | Эрүүл мэндийн яам, аймгийн Эрүүл мэндийн газар, сумын Эрүүл мэндийн төвөөс гаргасан мэдээ мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор Засаг даргын Тамгын газрын фейсбүүк хаягт байршуулах, шейрлэх, багуудын групп чат руу шейрлэж мэдээлэл хүргэсэн байна. | 80 |
| 5 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 1.2 Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.*** | | | | | | |
| 6 | Зорилт 1.2.1. Эмнэлгийн нэг удаагийн багаж хэрэгсэл, ариутгалын бодис, эм тарианы нөөцийн бэлэн байдлыг хангана. | | | | | | |
| 7 | Арга хэмжээ 1.2.1.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл,ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлнэ. | | Нөөц бүрдүүлэлтийн хувиар | 2 сарын нөөцтэй | 2-оос дээш сарын нөөц бүрдүүлсэн байна. | 2024 оны 12 сарын байдлаар сумын хэмжээнд Ковид-19 халдвар бүтгэгдээгүй бөгөөд халдвар хамгаалалын эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисын 2 сарын нөөцийг сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран бүрдүүлэн ажиллаж байна. Үүнд Комбинзон 60 ширхэг, халад 120 ширхэг , малгай 200 ширхэг , бээлий 40 хайрцаг, маск N94 200 ширхэг, маск энгийн 1200 ширхэг, түргэвчилсэн оношлуур 250 ширхэг, ХГУ шинжилгээний орчин 150 ш ирхэг байна. | 100 |
| 8 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 1.3.Цар тахлын эрсдлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зарцуулах зорилгоор гамшигийн эрсдлийн нөөц сангийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.*** | | | | | | |
| 9 | Зорилт 1.3.1. Эрсдлийн сангийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 10 | Арга хэмжээ 1.3.1.1. Эрсдлийн сангийн санхүүжилтийг нэмэгдүүлж батлах саналыг ИТХ-д оруулах | | Нэмэгдсэн мөнгөн дүнгийн хэмжээгээр | Батлагдсан төсөв 8 сая төгрөг | 5 сая төгрөгөөс доошгүй дүнгээр нэмэгдүүлнэ. | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2024 онд эрсдэлийн сангийн 2024 оны төсөвт мөнгө хуваарилаагүй бөгөөд 2023 оны 12-р сард хуралдсан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арвантавдугаар хуралдаанаар эрсдэлийн сангийн хөрөнгийн орон нутгийн татварын давсан орлого буюу сумын төрийн сангийн үлдэгдлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | | | | | | нөөц бололцоонд тулгуурлан 10.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан. 2024 оны төсвийн тодотгол хэлэлцэхэд 4.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн батлуулсан. | |
| 11 | Зорилт 1.3.2.Хандив,тусламж бусад хэлбэрээр эрсдлийн сангийн хөрөнгийг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 12 | Арга хэмжээ 1.3.2.1. Эрсдлийн сангийн хөрөнгийг хандив, тусламж, бусад хэлбэрээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | | Нэмэгдсэн хөрөнгийн хувь | 12,5 хувиар нэмэгдүүлсэн. | 15 хувиар нэмэгдүүлсэн байх. | 2023-2024 оны өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Цогт-Оршихын санаачилгаар Малчдадаа тусалъя аяныг зохион байгуулж, аяны хүрээнд цугласан 3800.0 мянган төгрөгийн бэлэн мөнгө, 15621.0 мянган төгрөгийн эд материалыг сумын эрсдлийн санд төвлөрүүлэн малчдад хуваарилан олгосон. Мөн төсвийн тухай хуулийн дагуу 2024 оны 12-р сард зардлын бүлэг хооронд шилжүүлгийн хүсэлтийг Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн хэмнэгдэж байгаа цалингийн сангийн зардлаас эрсдэлийн сангийн хөрөнгөд 5.0 сая төгрөгийг шилжүүлж нэмэгдүүлэн ажилласан. | 100 |
| 13 | **2. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | | | |
| 14 | **2.2. Биеийн тамир, спортын чиглэлээр**<br>***Стратегий төлөвлөгөөний зорилго 2.2.1. Сумын аварга шалгаруулах уралдаан тэмцээнийг жил бүр зохион байгуулна*** | | | | | | |
| 15 | Зорилт 2.2.1.1. Сумын аварга шалгаруулах Гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулах | | | | | | |
| 16 | Арга хэмжээ 2.2.1.1.1. Гар бөмбөгийн спортыг суманд хөгжүүлэх, хичээллэгсэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор иргэд, төрийн албан хаагчид, багуудын дунд гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн | | Оролцсон баг тамирчдын тоо | 2022 онд эрэгтэй 10, эмэгтэй 8 баг оролцсон. | Эрэгтэй, эмэгтэй тус бүр 10-аас доошгүй баг тамирчид оролцсон байна. | Монгол Улсын Ардчилсан үндсэн хуулийн ойн өдөрт зориулсан 2024 оны сумын аварга шалгаруулах насанд хүрэгчдийн “Волейбол”–ын тэмцээн 2024 оны 01 сарын 20,21–ний өдрүүдэд зохион байгуулж, тэмцээнд 17 багийн 136 тамирчин хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулна. | | | | | нийт 1,5 сая төгрөгийн төсвийг зарцууллаа.. | |
| 17 | Зорилт 2.2.1.2. Сумын аварга шалгаруулах Сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулах | | | | | | |
| 18 | Арга хэмжээ 2.2.1.2.1. Сагсан бөмбөгийн спортыг суманд хөгжүүлэх, хичээллэгсэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор иргэд, төрийн албан хаагчид, багуудын дунд гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулна. | | Оролцсон баг тамирчдын тоо | 2022 онд зохион байгуулагдаагүй. | Эрэгтэй, эмэгтэй тус бүр 8-аас доошгүй баг тамирчид оролцсон байна. | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах зорилгоор сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газартай хамтран сумын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнийг 2024 оны 05 сарын 22-ны өдөр зохион байгуулж нийт эрэгтэй 9, эмэгтэй 8 баг тамирчид оролцлоо. | 100 |
| 19 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго* 2.2.2. Мини олимп, Хаан цом, Залуучуудын урлаг спортын наадмыг зохион байгуулна.** | | | | | | |
| 20 | Зорилт 2.2.2.2. Хаан цом спортын наадмыг зохион байгуулна | | | | | | |
| 21 | Арга хэмжээ 2.2.2.3.1. Багуудын дунд Хаан цом спортын наадмыг зохион байгуулна. | | Хамрагдсан баг, тамирчдын тоо | 2023 онд зохион байгуулагдаагүй | 15 баг, 200-аас дээш тамирчин оролцуулна | Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, сумын иргэдийн спортоор хичээллэх сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 11 сарын 23,24-ний өдрүүдэд Улаанбаатар хотод төгсөгчдийн дунд Хаан цом" спортын наадам зохион байгуулж, 28 төгсөлтийн 400 гаруй төгсөгчид спортын 6 төрлөөр 216 багц медалийн төлөө өрсөлдсөн. Уг тэмцээнд 17.0 сая төгрөг зарцуулсан. | 100 |
| 22 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 2.2.3. Монголын үндэсний спорт, уламжлалт тоглоом наадгайг сэргээн хөгжүүлэхэд анхаарч дэмжиж ажиллана.*** | | | | | | |
| 23 | Зорилт 2.2.3.1. Үндэсний спорт, уламжлалт тоглоом наадгайн уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулна. | | | | | | |
| 24 | Арга хэмжээ 2.2.3.1.1. Сумын заан цолтнуудад хүндэтгэл үзүүлэх сумын заан цолтой бөхчүүдийн нэлттэй | | Хамрагдсан бөхчүүдийн тоо | 2023 онд 64 бөх | 50-с доошгүй бөхчүүдийг хамруулна. | "Хааны хүчтэн" бөхийн холбооны санаачлагаар жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг "ЭБЭГ" ХХК-ны нэрэмжит сумын заан цолтой | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | барилдаан зохион байгуулна. | | | | | болон цолгүй залуу бөхчүүдийн 3 дахь удаагийн нээлттэй барилдаан 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Жаргалтхаан суманд зохион байгуулагдаж суманд үйл ажиллагаа явуулдаг газар тариалангийн “ЭБЭГ” ХХКомпани 10 сая төгрөгөөр ивээн тэтгэлээ. | |
| 25 | Арга хэмжээ 2.2.3.1.2. Сар шинийн баярт зориулсан бөхийн барилдаан болон шагайн харвааны тэмцээн зохион байгуулна. | | Хамрагдсан бөхчүүд харваачдын тоо | 2023 онд зохион байгуулагдаагуй | 30-с доошгүй бөхчүүд, 50-аас доошгүй харваач хамруулна. | 2024 оны 5 сард сар шиний баярт зориулсан сумын Засаг даргын нэрэмжит Үндэсний шагайн харвааны сумын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд өсвөрийн 11, насанд хүрэгч 20, нийт 31 харваач, сонирхогч оролцлоо. | 100 |
| 26 | Зорилт 2.2.3.2. Үндэсний спорт, уламжлалт тоглоом наадгайг хөгжүүлэх, залуу хойч үедээ сургах сургалт, дугуйлан секц хичээллүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | | | | | | |
| 27 | Арга хэмжээ 2.2.3.2.1. Шагайн харвааны дугуйлан хичээллүүлэх | | Хичээллэж байгаа хүний тоо | 2023 онд 37 хүн хүчээллэсэн | Хичээллэгсдийн тоог 10-аас доошгүйгээр нэмэгдүүлнэ. | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд шагайн харвааны дугуйлан тогтмол хичээллэдэг бөгөөд өмнөх оныхоос хичээллэдэг сурагчдын тоо 5-аар нэмэгдсэн байна. Насанд хүрэгчдийн шагайн харваа сонирхогчдын дунд дугуйлан тогтмол хичээллэдэг бөгөөд нийт 37 иргэн хамрагдаж байна. | 80 |
| 28 | Арга хэмжээ 2.2.3.2.3. Үндэсний сурын харвааны сургалт, тэмцээн зохион байгуулж, хичээллэгсдийг нэмэгдүүлнэ. | | Сурын спортоор хичээллэж эхэлсэн хүний тоо | 2022 онд 8 хүн хичээллэсэн | Хичээллэгсдийн тоог 5-р нэмэгдүүлнэ. | Ерөнхий боловсролын сургуулийн 17 сурагч сумын мэргэн А.Баяржаргалаар удирдуулан Үндэсний сурын харваагаар тогтмол хичээллэж байна. 2024 оныг 2023 онтой харьцуулахад үндэсний сурын харваагаар хичээллэдэг сурагчийн тоо 5-р нэмэгдсэн байна. | 90 |
| 29 | ***Стратегитөлөвлөгөөний зорилго 2.2.4. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, эрүүл идэвхтэй амьдрах дадал олгох, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.*** | | | | | | |
| 30 | Зорилт 2.2.4.1. Биеийн тамирын орон тооны аргазүйч ажлуулна. | | | | | | |
| 31 | Арга хэмжээ 2.2.4.1.1. Нийтийн | | Гэрээний | 2023 онд | Гэрээний | Суманд орон тооны бус биеийн | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | биеийн тамирын арга зүйч ажиллуулж, үйл ажиллагааны үр дүнг дүгнэсэн байна. | | гүйцэтгэлийн хувь | гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй | гүйцэтгэлийг хувийг 70 хувьд хүргэнэ. | тамирын арга зүйчээр Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш Б.Батзориг ажиллаж байна. Суманд зохион байгуулагддаг спортын бүх төрлийн арга хэмжээнд ажлын хэсэгт орж ажилладаг. Орон тооны бус биеийн тамирын арга зүйчтэй байгуулсан гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэн ажиллаж байна. | |
| 32 | Арга хэмжээ 2.2.4.1.2. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ. | | Арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо | 2023 онд 6 арга хэмжээ зохион байгуулсан. | 2024 онд 8-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | 2024 онд олон нийтийг хамарсан спортын томоохон 6 арга хэмжээ зохион байгуулагдсан. Үүнд:<br>1. Монгол Улсын Ардчилсан үндсэн хуулийн ойн өдөрт зориулсан 2024 оны сумын аварга шалгаруулах насанд хүрэгчдийн “Волейбол”–ын тэмцээн 2024 оны 01 сарын 20, 21–ний өдрүүдэд зохион байгуулсан нийт 1,5 сая төгрөгийн төсөв гарсан.<br>2. “Хааны хүчтэн” бөхийн холбооны санаачлагаар жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “ЭБЭГ” ХХК-ны нэрэмжит сумын заан цолтой болон цолгүй залуу бөхчүүдийн 3 дахь удаагийн нээлттэй барилдаан 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Жаргалтхаан суманд зохион байгуулагдаж суманд үйл ажиллагаа явуулдаг газар тариалангийн “ЭБЭГ” ХХКомпани 10 сая төгрөгөөр ивээн тэтгэлээ.<br>3. Хэнтий аймгийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдсан Төрийн албан хаагчдын 5 төрөлт спортын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | наадамд сумаа төлөөлөн 32 албан хаагч оролцож 2,1 сая төгрөг зарцуулсан.<br>4. Сумын аварга шалгаруулах Адуучин тэмцээнийг 08 сарын 11-ний өдөр зохион байгуулж, нийт 43 адуучин оролцож, тэмцээнд нийт 3 сая төгрөг зарцуулсан.<br>5. Аймгийн аварга шалгаруулах “Адуучин” тэмцээнийг 08 сарын 12-ны өдөр зохион байгуулж, сум тус бүрээс 2 адуучин нийт 52 адуучин оролцсон тэмцээнийг зохион байгуулсан.<br>6. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, сумын иргэдийн спортоор хичээллэх сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 11 сарын 23,24-ний өдрүүдэд Улаанбаатар хотод төгсөгчдийн дунд Хаан цом” спортын наадам зохион байгуулж, 28 төгсөлтийн 400 гаруй төгсөгчид спортын 6 төрлөөр 216 багц медалийн төлөө өрсөлдсөн. Уг тэмцээнд 17.0 сая төгрөг зарцуулсан. | |
| 33 | Зорилт 2.2.4.2. Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг чадваржуулах, дэмжих, төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх замаар хамтран ажиллаж, биеийн тамираар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 33 | Арга хэмжээ 2.2.4.2.1. Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, эрүүл идэвхтэй амьдрах талаар сургалт, сурталчилгааны ажил зохион | | Зохион байгуулсан сургалтын тоо | 2023 онд 1 сургалт зохион байгуулсан. | 2024 онд 3-с доошгүй сургалт зохион байгуулна. | Хэнтий аймгийн Биеийн тамир спортын газартай хамтран ажиллаж сумын иргэдээс бие бялдарын түвшин тогтоох сорил авч, эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг, дасгал хөдөлгөөнөөр хичээллэж байхын ач тусын талаар сорилд оролцогч иргэдэд сургалт зохион байгуулсан. | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулна. | | | | | | |
| 34 | Арга хэмжээ 2.2.4.2.2. “ Бие бялдарын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын үйл ажиллагаар тогтмол зохион байгуулж, иргэдийг хамруулах | | Сорилд хамрагдачдын тоо | 2023 онд 40 иргэн | 40 хүн | Бие бялдарын түвшин тогтоох сорилд төсөвт байгууллагуудын албан хаагчдыг болон сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг хамруулж сорилын программд бүртгэлээ. Цэцэрлэг 24 хүүхэд, сургуулийн 98 сурагч, Засаг даргын Тамгын газар 16 албан хаагч, Цэцэрлэгийн 11 багш, Ерөнхий боловсролын сургуулийн 23 багш, ажилчин, Эрүүл мэндийн төвийн 15 албан хаагч хамрагдлаа. | 100 |
| 35 | Зорилт 2.2.4.3. Иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчлах, хэвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 36 | Арга хэмжээ 2.2.4.3.1. Зумба дасгал зохион байгуулна. | | Оролцсон хүний тоо | 2023 онд зохион байгуулагдаагүй. | 50-аас доошгүй хүнийг хамруулна. | Засаг даргын Тамгын газар Соёлын төв, Ахмадын хороо, Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх зорилгоор 2024 оны 4,5-р сард зумбо дасгалыг зохион байгуулсан. Дасгалд 25 ахмад настан, ЗДТГ-ын 24 албан хаагч, Соёлын төвийн 5 албан хаагч, нийт 54 иргэн хамрагдсан. | 100 |
| 37 | Зорилт 2.2.4.4. Нийтийн цэнгээнт бүжгийн сургалт зохион байгуулах | | | | | | |
| 38 | Арга хэмжээ 2.2.4.4.1. Иргэд, төрийн албан хаагчдад Цэнгээнт бүжгийн сургалт зохион байгуулна. | | Сургалтад хамрагдсдын тоо | 2023 онд 140 хүн хамрагдсан | Сургалтад хамрагдсдын тоо 100 | Нийтийн цэнгээнт бүжгийн багш С.Оюунцэцэгтэй гэрээ байгуулан 2024 онд иргэд, төрийн албан хаагчдад Цэнгээнт бүжгийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 162 хүн хамруулж, Венгерка, Түстэп, Полька, Фокстрот, Сургуулийн вальс зэрэг бүжгүүдийг заасан. | 100 |
| 39 | **2.3 Боловсролын чиглэлээр** | | | | | | |
| 40 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 2.3.3. Сургууль, цэцэрлэгийн багш нарын ёс зүйн дүрмийн хэрэгжилт, мэргэжлийн ур чадварт жил бүр үнэлгээ хийж, үр дүнг тооцож ажиллана.*** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 41 | Зорилт 2.3.3.1. Багш нарын ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах сургалт нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж, ёс зүйн дүрмийн хэрэгжилт, мэргэжлийн ур чадварт үнэлгээ хийж, үр дүнг тооцож ажиллана. | | | | | | |
| 42 | Арга хэмжээ 2.3.3.1.1. Багш нарын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах, ёс зүйн дүрмийг танилцуулах сургалтыг ЕБС-ийн ёс зүйн багтай хамтран зохион байгуулна. | | Зохион байгуулсан сургалтын тоо | 2022 онд 2 удаа сургалт зохион байгуулсан. | 2-с доошгүй удаа зохион байгуулна. | 2024 оны 5 сард сургуулийн Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэгдсэн. Сургалт, нөлөөллийн ажлын төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг аймгийн БШУГ-ын мэргэжилтэн Г.Мөнхчимэгт тухай бүрт нь хүргүүлж ажилласан. Засаг даргын Тамгын газар нь тус ёс зүйн багтай хамтран нөлөөллийн ажил 1 удаа хийж, төрийн албан хаагчийн мөн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ёс зүйн дүрмийн сургалтыг 2 удаа хийж, 40 албан хаагчаар баталгаа гаргуулж ажиллалаа. Төрийн албаны зөвлөлөөс зохион явуулсан төрийн албан хаагчийн ёс зүй, авилгын тухай ойлголт сургалтад 40 албан хаагчийг хамруулсан. Сургуулийн эцэг эх, асран хамгаалагчдад Боловсролын ерөнхий хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний талаар 1 удаа сургалт хийж, 48 эцэг эх хамрагдсан. | 80 |
| 43 | Зорилт 2.3.3.2. Сурагчид, эцэг эхчүүдээс багш нарын ёс зүй, мэргэжлийн ур чадварын талаар сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр авч, үр дүнг тооцож ажиллана. | | | | | | |
| 44 | Арга хэмжээ 2.3.3.2.1. Төрийн байгууллагуудад хийх хяналт шалгалтын ажлын хүрээнд багш нарын ёс зүй, ур чадварын талаар сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгаанд суурилан үр дүнг дээшлүүлэх арга хэмжээг | | Судалгаанд оролцогчдын тоо | 2023 онд нэг удаа авсан | Улиралд 150 иргэн | Сумын Засаг даргын баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, ажлын үр дүнг үнэлэх тухай” удирдамжийн хүрээнд төрийн байгууллагуудын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, сумын төсөвт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулна | | | | | байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөн туслах зорилгоор Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд томилогдсон ажлын хэсгийн гишүүд ажиллаж бодлогын баримт бичиг, түүний уялдаа, тайлагналт зэрэгтэй танилцаж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол болон аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжаар баталсан журам, аргачлалын дагуу үнэлгээ өгч, үнэлгээг сумын Засаг дарга болон Байгууллагын дарга нарт танилцуулж, зөвлөмж өгч ажиллалаа. | |
| 45 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 2.3.5. Суманд шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа, элсэлтийн шалгалтанд өндөр оноо авсан, амьжиргааны түвшин доогуур өрхийн суралцагчдад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ.*** | | | | | | |
| 46 | Зорилт 2.3.5.1. Суманд шаардлагатай мэргэжлээр сурч байгаа болон амжиргааны түвшин доогуур өрхийн голч оноо өндөртэй суралцагчдыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах, сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх ажлыг хийж хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 47 | Арга хэмжээ 2.3.5.1.1. Сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, шалгуурын дагуу тэтгэлэг олгоно. | 15000.0 | Тэтгэлэг олгосон оюутны тоо | 2023 онд 10 оюутанд тэтгэлэг олгосон. | 10-аас дээш оюутанд дэмжлэг үзүүлнэ. | Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны арвантавдугаар хуралдаанаар Сургалтын төлбөрийн тэтгэлэгт хөтөлбөрийг батлуулан гаргаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд 15.0 сая төгрөгийг төсөвлөж, 8-р сард сургалтын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах хүсэлтийг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтнээр дамжуулан авч, хүсэлт ирүүлсэн 15 оюутанд тус бүр 1.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн тэтгэлэгийг олгосон. | 100 |
| 48 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 2.3.6. Цэцэрлэг, сургуулийн барилгыг засварлаж, өргөтгөх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, орчин нөхцлийг сайжруулах ажлыг хийж хэрэгжүүлнэ.*** | | | | | | |
| 49 | Зорилт 2.3.6.1. Сургуулийн тавилга, тоног төхөөрөмж / компьютер/-ийг нэмэгдүүлж, шинэчилнэ. | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 50 | Арга хэмжээ 2.3.6.1.1. Ерөнхий боловсролын сургуульд сумын ОНХСангийн хөрөнгөөр тавилга, тоног төхөөрөмж нэмэгдүүлнэ. | 20000.0 | Тавилга, тоног төхөөрөмжийн тоо, мөнгөн дүн | 2023 онд тоног төхөөрөмж нэмэгдээгүй | 5-с доошгүй тооны тавилга, тоног төхөөрөмж нэмэгдүүлнэ. | Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүүхдийн сурч боловсрох орчныг сайжруулах, хүртээмжтэй, тав тухтай орчныг бий болгох ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуульд нэн шаардлагатай мэдээлэл зүйн танхимын ширээ, сандал, дуу бичлэгийн студийн дууны тоног төхөөрөмж өсгөгч, пульт, хими, физикийн хичээлийн туршилтыг виртуал орчинд хийх цахим лаборатори зэргийг сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шийдвэрлэн хүлээлгэж өгсөн. | 100 |
| 51 | Арга хэмжээ 2.3.6.1.2. Ерөнхий боловсролын сургуулийн хуучин спорт заалыг сумын ОНХСангийн хөрөнгөөр засварлана. | 42000.0 | Засварын ажлын гүйцэтгэлийн хувь | 2023 онд засварлаагүй | Засварын ажлын гүйцэтгэл 100% | Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгөөр хийгдэх “Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны засвар, тохижилт”-ын ажлын худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулж, тендерт шалгарсан “Шижир цагаан” ХХК-тай 70.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, Ерөнхий боловсролын сургуулийн хуучин сургуулийн спорт заалыг засварлуулж 2024 оны 12 сарын 10-ны өдөр ашиглалтад хүлээж авсан. | 100 |
| 52 | Арга хэмжээ 2.3.6.1.3. Ерөнхий боловсролын сургуулийн хуучин барилгыг сумын ОНХСангийн хөрөнгөөр засварлана. | 40000.0 | Засварын ажлын гүйцэтгэлийн хувь | 2023 онд засварлаагүй | Засварын ажлын гүйцэтгэл 100% | Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгөөр хийгдэх “Ерөнхий боловсролын сургуулийн хуучин барилгын засвар”-ын ажлын худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулж, тендерт шалгарсан “Топ инженеринг солюшн” ХХК-тай 60.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, Ерөнхий боловсролын сургуулийн хуучин сургуулийн 4 ангийг засварлуулж, 2024 оны 12 сарын 05-ны өдөр ашиглалтад хүлээж авсан. Тус засвар хийсэн 4 өрөөнд төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, орон байраар хангах хөтөлбөрийн хүрээнд тус суманд ирж ажиллаж байгаа Ерөнхий боловсролын сургуулийн багш, цэцэрлэгийн багш зэрэг 4 төрийн албан хаагчийг байрлуулаад байна. | |
| 53 | Арга хэмжээ 2.3.6.1.4. Ерөнхий боловсролын сургуульд фитнес танхимыг сумын ОНХСангийн хөрөнгөөр байгуулна. | 20000.0 | Хэрэгжилтийн хувь | 2023 онд байгаагүй | Бүрэн байгуулна 100% | Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 онд хийж хэрэгжүүлэх ажлын жагсаалтад орсон “Ерөнхий боловсролын сургуудьд хүүхэд хөгжлийн танхим байгуулах ажлын гэрээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулж, тендерт шалгарсан СИ-ТИ-АР ХХК-тай тус ажлыг 29.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэх гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлэн, 2024 оны 10 сарын 08-ны өдөр ашиглалтад хүлээж авсан. Ерөнхий боловсролын сургуулийн нэг ангийг фитнес танхим болгон засварлаж фитнесийн шал, гүйлтийн зам 1 ширхэг, олон үйлдэлт смит төхөөрөмж 1 ширхэг, фитнес диск 12 ширхэг, фитнес гантель 10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ширхэг, нурууны сунгалтын төхөөрөмж 1 ширхэг, хэвлийн вандан 1 ширхэг, хэвтээ шахалтын вандан 1 ширхэг, нурууны сунгалтын төхөөрөмжийг тус тус суурилуулсан. | |
| 54 | Арга хэмжээ 2.3.6.1.5. Ерөнхий боловсролын сургуульд хүүхэд хөгжлийн танхимыг сумын ОНХСангийн хөрөнгөөр байгуулна. | 30000.0 | Ашиглалтын хувь | 2023 онд байгаагүй | Бүрэн ашиглалтад оруулна 100% | Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 онд хийж хэрэгжүүлэх ажлын жагсаалтад орсон "Ерөнхий боловсролын сургуудьд хүүхэд хөгжлийн танхим байгуулах ажлын гэрээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу иргэн С.Цэнгэлжаргалтай тус ажлыг 20.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэх гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлэн, 2024 оны 11 сарын 12-ны өдөр хүлээж авсан. | 100 |
| 55 | Зорилт 2.3.6.3. 50 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгын өргөтгөлийг барьж, ашиглалтанд оруулна. | | | | | | |
| 56 | Арга хэмжээ 2.3.6.3.1. Сумын ОНХСангийн хөрөнгөөр хүүхдийн цэцэрлэгт тавилга, зөөлөл эдлэл нэмэгдүүлнэ | 20000,0 | Зөөлөн эдлэл, тавилгын тоо, мөнгөн дүн | 2023 онд зөөлөн эдлэл нэмэгдээгүй | 125-с доошгүй тооны зөөлөн эдлэл, 5-с доошгүй тавилга, тоног төхөөрөмж нэмэгдүүлнэ. | Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүүхдийн сурч боловсрох орчныг сайжруулах, хүртээмжтэй, тав тухтай орчныг бий болгох ажлын хүрээнд Хүүхдийн цэцэрлэгт нэн шаардлагатай гал тогооны тоног төхөөрөмж/ хөргүүр, аяга таваг ариутгагч, махны цахилгаан машин, 3 дамжлагат аяга угаагч гм/, хүүхдийн ор, ширдэг/ дрож /, тоос сорогч, тоглоом зэргийг сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шийдвэрлэн хүлээлгэж өгсөн. | 100 |
| 57 | **2.4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр**<br><br>***Стратеги төлөвлөгөөний зорилго 2.4.1. Ахмад настнуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлж, хамтарч ажиллах санаачлагыг бүх талаар дэмжиж ажиллана.*** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 58 | Зорилт 2.4.1.1. Ахмадын өдөрлөгийг 2 сар тутам зохион байгуулах | | | | | | |
| 59 | Арга хэмжээ 2.4.1.1.1. Ахмадуудад зориулсан уулзалт, өдөрлөг зохион байгуулна. | | Арга хэмжээний тоо, ахмадын хамрагдалтын хувь | 2023 онд 3 удаа ахмадын өдөрлөг зохион байгуулсан. | 5-аас доошгүй удаа өдөрлөг зохион байгуулж, нийт ахмадын 80-аас доошгүй хувийг хамруулна. | Суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд Ахмад настны тухай хуулийн 12.1. Жил бүрийн Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдөр: 10 дугаар сарын 1-ний өдрөөс гадна улирал бүр ахмадын өдөрлөгийг хариуцан зохион байгуулан ажиллаж байна. 2024 оны 3-р сард Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, 5-р сард Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, 8-сард Соёлын төв, Эрүүл мэндийн төв, 11-р сард Засаг даргын Тамгын газар ахмадын өдөрлөгийг Ахмадын хороотой хамтран зохион байгуулж, 4 удаагийн ахмадын өдөрлөгт 227 ахмадыг хамруулсан нь нийт ахмадын 80.2 хувьтай тэнцэж байна. | 100 |
| 60 | Зорилт 2.4.1.2. Сар шинийн баяр, Ахмадын баяраар сумын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх | | | | | | |
| 61 | Арга хэмжээ 2.4.1.2.1. Хуулийн дагуу ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | | Оролцсон ахмадын хувиар | Жилд 2 удаа нийт ахмадуудыг 1000 хувь хамруулсан. | Цагаан сар, Ахмадын өдрөөр хүндэтгэл үзүүлж,нийт ахмадуудыг 100 хувь хамруулна. | Ахмад настны тухай хуулийн 12.1. Жил бүрийн Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдөр: 10 дугаар сарын 1-ний өдрийг тохиолдуулан аж ахуйн нэгж, байгууллага бүр ажиллаж байсан ахмад настанд хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулна" гэсний дагуу ахмад настанд үзүүлэх хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд харьяалалгүй 236, харьяалалтай 47, нийт 283 ахмадыг бүрэн хамруулж, 7,070,000 мянган төгрөгийн хүндэтгэл үзүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 62 | Зорилт 2.4.1.3. Төсөвт байгууллагуудад Ахмадын сан байгуулж, ахмад настнуудад чиглэсэн арга хэмжээг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 63 | Арга хэмжээ 2.4.1.3.1. Байгууллагуудад Ахмадын сан байгуулна. | | Сан байгуулсан байгууллагын тоогоор | 2023 онд байгуулаагүй | Төсвийн 4-өөс доошгүй байгууллагад сан байгуулсан байна. | Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль зэрэг байгууллагууд ахмадын сан байгуулсан бөгөөд 2024 оны төсөвт ахмадын санд 0.5-1.5 сая төгрөгийг төсөвлөн зарцуулсан бөгөөд 2025 оны төсөвт Ахмадын сангийн журмын дагуу цалингийн сангийн хэмнэлтээс өмнөх оны төсвийг 2 дахин нэмэгдүүлж батлуулах санал оруулахаар боловсруулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барихаар бэлтгээд байна. | 90 |
| 64 | Зорилт 2.4.1.4. Ахмадын хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулах | | | | | | |
| 65 | Арга хэмжээ 2.4.1.4.1. Ахмадын хөгжлийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр тохижуулах ажлыг хандивын хөрнгөөр хийнэ. | 2000.0 | Нийт хөрөнгийн дүн, тоног төхөрөмжийн тоо | 2023 онд хийгээгүй. | 2024 онд 2000.0 төгрөгийн 1-2 тоног төхөөрөмжөөр тохижуулна. | Тус суманд газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг ЭБЭГ ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжин 1500.000 төгрөгийн үнэ бүхий принтер, кофе чанагч, даралтын аппарат зэрэг тоног төхөөрөмжүүдийг авч өгсөн. | 80 |
| 66 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 2.4.2. "Ажлын байр- Жаргалтхааны хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.*** | | | | | | |
| 67 | Зорилт 2.4.2.1. Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан үе шаттай хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 68 | Арга хэмжээ 2.4.2.1.1. Ажлын байр-Жаргалтхааны хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг хангаж ажиллах | | Ажлын байраар хангагдсан иргэдийн тоо, хэрэгжилтийн хувь | 2023 онд байнгын ажлын байраар 22, түр ажлын байраар 80 иргэн хангагдсан. | 2024 онд байнгын ажлын байраар 15-с доошгүй, түр ажлын байраар 40-аас доошгүй иргэн, хэрэгжилт 80-аас доошгүй хувь | Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны арвантавдугаар хуралдаанаар "ажлын байр-Жаргалтхааны хөгжил хөтөлбөр"-ийг батлуулан гаргаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд 3.0 сая төгрөгийг төсөвлөж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаn өрхийн үйлдвэрлэл эрхлэн, өрхийн орлогоо нэмэгдүүлж өөрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өвчтэй эхнэрээ асарч байгаа иргэн Н.Баасанжавт төмөр хуйлах тоног төхөөрөмжийг олгосон. | |
| 69 | Арга хэмжээ 2.4.2.1.2. Нийгмийн хамалмжийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрт зуучилж, хамруулах | | Хамрагдсан иргэдийн тоо | 2023 онд 40 | 5-аас доошгүй иргэнийг хамруулна. | Өвөлжилтийн байдал хүндэрч зудын байдалд шилжиж, мал олон тоогоор ухэж хорогдсон. Үүнээс шалтгаалан малын сэг зэм хаа сайгүй болсон тул иргэдийг байгль эх орныхоо орчинг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор Сэг зэм устгалын ажилд 67 иргэнийг 10 хоног ажиллуулж 24,120,000 төгрөгийн ажлын хөлсийг олгож, түр ажлын байраар хангаж байна. | 100 |
| 70 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 2.4.4. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, өрх, гэр бүлийн хөгжлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.*** | | | | | | |
| 71 | Зорилт 2.4.4.1. Хамтарсан баг, Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг чадавхижуулж, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулна. | | | | | | |
| 72 | Арга хэмжээ 2.4.4.1.1. Хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмолжуулж, хариуцлагыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг тайлагнаж ажиллах | | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | 1 удаа хамрагдсан | Биелэлтийг 80-аас дээш хувьд | Жаргалтхаан сумын хамтарсан баг нь өмнө нь 9 гишүүнтэй байсан 2024 оны 06 сарын 13-ны сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 18 дугаар хуралдаанаар Хамтарсан багийн гишүүдийг шинэчлэн байгуулж багийн Засаг дарга нарыг гишүүнээр нэмснээр 14 гишүүнтэй болсон. Хамтарсан багийн хурлыг сар бүрийн эхний 7 хоногийн Лхагва гарагт хийдэг. Сумын хэмжээнд эрсдэлт нөхцөлд байдаг 21 хүүхэд байдаг. Гэрийн эргэлтийг хамтарсан багийн гишүүд тогтмол хийж ажилладаг бөгөөд шаардлагатай тохиолдолд өдөр бүр эргэдэг.<br>Хамтарсан баг нь 2024 онд 3 зорилт 16 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг 12-р сард | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулагдсан хамтарсан багийн хурлаар хэлэлцүүлж, 82 хувьтай биелүүлж ажиллалаа. Мөрөн суманд зохион байгуулагдсан Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах бүсийн сургалтанд хамтарсан багийн 5 гишүүн хамрагдсан. | |
| 73 | Арга хэмжээ 2.4.4.1.2. Гэр бүлийн хүчирхийллийн харилцаатай өрхүүдийг сонгож тусгайлсан хөгжлийн хөтөлбөр батлан хэрэгжүүлж ажиллах | | Хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамрагдсан гэр бүлийн тоо | Өмнө нь ажиллаж байгаагүй. | 5 гэр бүл хамруулна | 5-р сарын 8,9 -ны өдрүүдэд Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас ажлын хэсэг ирж хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг 60 иргэн, 53 сурагч, 40 цэцэрлэгийн хүүхэд, нийт 153 иргэнд үзүүлсэн. Мөн зан үйлийн эрсдэл, бэрхшээл, хүүхдийн харилцаа хандлага, сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай холбоотой 12 хүүхдэд сэтгэлзүйчийн үйлчилгээ үзүүлж, 2 өрхөөр гэрээр айлчлан нөхцөл байдлын үнэлгээ хийж ажилласан.<br>Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1 хохирогчийг хамгаалах байранд хүргэж өгөх ажлыг зохион байгуулсан. | 80 |
| 74 | Арга хэмжээ 2.4.4.1.3. “Аймгийн хүүхдийн хөгжил хамгааллын жилийн төлөвлөгөөг”-г үндэслэн сумын жилийн ажлын төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | | Хэрэгжилтийн хувь | 2023 онд хэрэгжилтийн хувь 88 | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90-с дээш хувь хэрэгжүүлнэ. | Жаргалтхаан сумын хүүхдийн төлөө зөвлөлийн төлөвлөгөөг 2 зорилт 10 арга хэмжээтэйгээр боловсруулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан. Төлөвлөгөөний биелэлт 86%-тай биелэсэн. | 86 |
| 75 | Зорилт 2.4.4.2. Гэр бүлийн гишүүд бүрт зориулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | | | | | | |
| 76 | Арга хэмжээ 2.4.4.2.1. Олон улсын гэр бүлийн өдрөөр гэр бүлд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулна. | | Хамрагдсан гэр бүлийн тоо | 2023 онд 1 арга хэмжээ | 1-с доошгүй гэр бүлийг хамруулна. | Олон улсын гэр бүлийн өдрөөр сумын хэмжээнд цахим мэндчилгээ явуулж, төрийн байгууллагуудын албан хаагчдынхаа дунд буухиа тэмцээн, нөлөөллийн арга хэмжээ зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан. Тэмцээнд 5 байгууллагын нийт 10 гэр бүл хүүхдүүдийн хамт хамрагдсан. | |
| 77 | Арга хэмжээ 2.4.4.2.2. Эх үрсийн баярыг зохион байгуулна. | | Хамрагдсан эх, хүүхдийн тоо | 2023 онд 350 хүүхэд хамрагдсан. | Арга хэмжээнд хүүхдүүдийн 50-с доошгүй хувийг хамруулна. | Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийн хүрээнд “Нэгдүгээрт хүүхэд” уриатай баярын жагсаалыг зохион байгуулж нийт 150 гаруй хүүхэд багачууд хамрагдсан. Сумын төсөвт байгууллагууд насны ангиллаар 8 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулж, нийт зохион байгуулсан арга хэмжээнд 253 хүүхэд хамрагдсан. | 100 |
| 78 | Арга хэмжээ 2.4.4.2.3. Олон улсын аавуудын өдрийг тэмдэглэн өнгөрүүлнэ. | | Хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамрагдсан хүний тоо | 0 | 1 арга хэмжээ зохион байгуулж, 50-с дээш аавуудыг хамруулна. | Олон улсын аавуудын өдөр буюу 2024 оны 08 сарын 08-ны өдөр Засаг даргын Тамгын газрын эмэгтэй албан хаагч нар хамт мөр зэрэгцэн ажиллаж байгаа 17 аавдаа Олон улсын аавуудын баярын мэндчилгээ дэвшүүлж, өөрсдийн зүгээс Засаг даргын Тамгын газрын бүх эрэгтэй албан хаагчдын зураг бүхий Гэр бүлийн аз жаргал аавaас эхлэнэ уриатай аягыг дурсгал болгон бэлэглэлээ. Мөн Ерөнхий болосролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл Мэндийн төв, Соёлын төв, Эрэн хайх аврах бүлэг, Цагдаагийн тасагт ажиллаж байгаа нийт 33 аавуудад Олон улсын аавуудын өдрийн зурагт мэндчилгээг хүргэж, баяр хүргэлээ. | 100 |
| 79 | Арга хэмжээ 2.4.4.2.4. Гэр бүлийн үнэт зүйлийг бэхжүүлж, хүчирхийллийг бууруулах сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах | | Хамрагдсан хүний тоо | 2023 онд 20. | 40-аас дээш гэр бүлийг хамруулсан байна. | Ерөнхий боловсролын сургуулийн эцэг, эх, асран хамгаалагчдын дунд “Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулж 45 эцэг, эх асран хамгаалагч оролцож, хүүхдийн эрх хүүхэд хамгааллын чиглэлээр саналаа солилцлоо. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 80 | Зорилт 2.4.4.3. Хүүхдэд ээлтэй орон нутгийн 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжиж, эрсдэлд нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж , хүүхдэд ээлтэй байдлын индексийг жилд 1 нэгжээр ахиулна. | | | | | | |
| 81 | Арга хэмжээ 2.4.4.3.1. Хүүхдэд амьдрах ухааны боловсрол олгох төлөвшүүлэх зорилготой зуслангийн хувилбарт арга хэмжээг сум өөрийн нөөц боломжит тулгуурлан хэрэгжүүлэх | | Хамруулсан хүүхдийн тоо, хагас, бүтэн өнчин хүүхдийН ээлэх хувь | 0 | 5 хүүхэд хамруулах, 20 хувь нь хагас, бүтэн өнчин | Дорнод аймагт зуслангийн хөтөлбөрт хамруулах 8 хүүхдийн /хагас, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн хүүхэд байх/ судалгааг гарган хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газарт хүргүүлж, хүүхдүүдийг зусланд хамруулах арга хэмжээг зохион байгуулсан.<br>Хүүхдэд амьдрах ухааны боловсрол олгох, төлөвшүүлэх зорилготой хөдөлмөр зуслангийн хувилбарт арга хэмжээг суманд хэрэгжүүлэх зорилгоор 07 сарын 01-ний өдрөөс эхлэн Хөдөлмөр зусланг Чулуут багийн малчин өрх Д.Баярсайхан, С.Энхтайван нартай хамтран 9-р ангийн 6 хүүхдийг хамруулсан. | 100 |
| 82 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 2.4.5. Иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, санал санаачлагыг дэмжиж, хамтарч ажиллана.*** | | | | | | |
| 83 | Зорилт 2.4.5.1. Сумын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, хоорондын харилцан хамаарлыг нэмэгдүүлэх | | | | | | |
| 84 | Арга хэмжээ 2.4.5.1.1. Залуучуудын зөвлөлтэй хамтран залуучуудыг соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлууд зохион байгуулна. | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо | 1 арга хэмжээ зохион байгуулж 50 иргэн хамрагдсан. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 100-аас доошгүй залуучуудыг хамруулсан байна. | Сумын залуучуудын зөвлөлтэй хамтран 2023-2024 оны өвөлжилт хүндэрч, их хэмжээний цас орсны улмаас хөдөө багууд руу явах зам даваа хаагдсантай холбогдуулан зам гаргах ажилд сумын залуучуудын зөвлөлийн 5 залууг 3 хоног ажиллуулсан нь бусдад өөрийн чаддаг зүйлээр тусалж дэмжих, бусдад үлгэрлэн дуурайлал үзүүлэх арга хэмжээ болсон..<br>Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хангах ажлын хүрээнд залуучуудын оролцоотой сайн дурын үйл | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 4,5-р сарыг “Дэлхийн сайн үйлсийн сар” болгон зарласантай холбогдуулан тус сумын Баян-Эрдэнэ багийн иргэн Л.Батбилэг нь сайн үйлсийн сарын аянд нэгдэж малчдадаа туслах зорилгоор хувиасаа 19 шуудай 3 тонн хужирыг өгсөн. | |
| 85 | Арга хэмжээ 2.4.5.1.2 Залуучуудад чиглэсэн спорт, урлагийн арга хэмжээ зохион байгуулна. | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан залуучуудын тоо | 1 арга хэмжээ зохион байгуулж, 250 залуучууд хамрагдсан. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулж 250 залуучуудыг хамруулна. | 2024 оны 11 сарын 23,24-ний өдрүүдэд Ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчдийн дунд зохион байгуулсан Хаан цом-2024 спортын наадмыг 6 төрлөөр зохион байгуулсан бөгөөд тус тэмцээнд 29-44-р төгсөлтийн 13 төгсөлтийн 262 төгсөгч оролцсон. | 100 |
| 86 | Арга хэмжээ 2.4.5.1.3. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлнэ. | | Хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо | 2022 онд 120 эмэгтэй хамрагдсан. | 150 эмэгтэйг хамруулна. | Олон улсын мартын 8-ны баярыг угтаж суманд зохион байгуулсан “Бүсгүйчүүд бид хамтдаа”-д арга хэмжээнд сумын 5 багийн 120 эмэгтэйг хамруулалаа. | 80 |
| 87 | Арга хэмжээ 2.4.5.1.4. Төр Улаан загалмайн хамтын ажиллагааны салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | - | Биелэлтийн хувь | 2023 онд 2 арга хэмжээ | Биелэлт 80-аас дээш хувьд | Сумын Засаг даргын 2022 оны А/27 дугаар захирамжаар сумын Төр-Улаан загалмайн хамтын ажиллагааны салбар зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. Тус зөвлөлөөс 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 7 арга хэмжээтэй боловсруулан батлаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 80.6 хувьтай биелүүлсэн. | 100 |
| 88 | Арга хэмжээ 2.4.5.1.5. Орон нутаг дахь Хүний эрхийн төлөв байдлын тайланг гаргаж хугацаанд нь Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэх | | Тайлагналтын хугацаа | 0 | Тайланг 12-р сарын 04-нд хүргүүлнэ | Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан Төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээний хавсралтын дагуу Жаргалтхаан сумын Хүний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрхийн төлөв байдлын тайланг гаргаж Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 12 сарын 05-ны өдрийн 02/132 дугаартай албан бичгээр Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэст егр системээр болон цаасаар хүргүүлсэн. | |
| 89 | Арга хэмжээ 2.4.5.1.6. Жендэрийн дэд салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, аймгийн Жендэрийн салбар хорооны 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах холбогдох тайлан мэдээний биелэлтийг гаргаж хүргүүлэх | | Тайлагналтын хугацаа | 0 | Тайланг 5-р сарын 31, 11-р сарын 29-нд хүргүүлнэ | Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан Төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээний хавсралтын дагуу Жендэрийн салбар хорооны 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах холбогдох тайлан мэдээний биелэлтийг гаргаж хүргүүлэх Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 12 сарын 13-ны өдрийн 02/137 дугаартай албан бичгээр Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэст егр цахим системээр хүргүүлсэн. | 100 |
| 90 | Зорилт 2.4.5.2. Иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхижуулах сургалт, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулна. | | | | | | |
| 91 | Арга хэмжээ 2.4.5.2.1. Иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхижуулах сургалтыг сургалтын байгууллагтай хамтран зохион байгуулна. | | Зохион байгуулсан сургалтын тоо | 2022 онд зохион байгуулаагүй. | 1 удаа зохион байгуулна. | Хэнтий аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс нь бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх кибер аюулгүй байдлын “Цахимд зөв байя” сургалтыг 2024 оны 11-р сарын 25-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус сургалтад 68 төрийн албан хаагч, 2 иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцсон. | 100 |
| 92 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 2.4.6. Хүүхэд залуусыг зөрөг харилцаа, хандлагатай, эрүүл зөв дадал хэвшилтэй, эртэч иргэн болгож төлөвшүүлэх зорилготой Зөрөг Жаргалтхаан арга хэмжээг хэрэгжүүлнэ.*** | | | | | | |
| 93 | Зорилт 2.4.6.1. Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан үе шаттай хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 94 | Арга хэмжээ 2.4.6.1.1. “Зөрөг Жаргалтхаан” хөтөлбөрийг | | Хэрэгжилтийн хувь | 2023 онд төлөвлөгөөний | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 95 | Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны арвантавдугаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах | | | хэрэгжилт 91 хувь | хувьд хүргэнэ | хуралдаанаар “Эерэг Жаргалтхаан хөтөлбөр”-ийг батлуулан гаргаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд 2.0 сая төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардалд тусгаж, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх 12 зорилт 24 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан сумын Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг ханщган ажиллаж төлөвлөгөөг 95 хувьтай биелүүлж ажиллалаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туссан заалтын хүрээнд сургалтын байгууллагатай хамтран төрийн албан хаагчдад эерэг харилцаа хандлага төлөвшүүлэх, байгууллагын соёлыг дэлгэрүүлэх нь сэдэвт сургалтыг 2024 оны 12 сарын 13-ны өдөр зохион байгуулсан. | |
| 95 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 2.4.7. Иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх гэрийн амьжиргааг дэмжих бодлогыг хэрэгжүүлж, “Гэр бэлэглэе”, “Байшин” төслүүдийг хэрэгжүүлнэ.*** | | | | | | |
| 96 | Зорилт 2.4.7.1. Халамжийн үйлчилгээ шаардлагатай зорилтот түвшний иргэдийг халамжийн үйлчилгээнд бүрэн хамруулна. | | | | | | |
| 97 | Арга хэмжээ 2.4.7.1.1. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хуулийн дагуу халамжийн үйлчилгээг зорилтод өрх иргэнд тэгш хүргэх | | Хамрагдсан иргэдийн хувь | 2023 онд 32 өрхийн 185 иргэн | Зорилтод бүлгийн иргэдийн 50-аас доошгүй хувийг хамруулна. | Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үйлчилгээнд 32 өрхийн 101 том хүн 74 хүүхэд хамрагдаж 26.976.000 төгрөгийн хүнс олгосон байна.<br>Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний сар бүрийн олголтыг тухайн сарын 20-ны өдөр олгож байна. | 100 |
| 98 | Зорилт 2.4.7.2. Халамжаас-Хөдөлмөрт арга хэмжээний хүрээнд зорилтот өрхийн иргэдийг мэргэжил олгох, ур чадвар эзэмшүүлэх сургалтанд хамруулж, ажлын байраар хангана. | | | | | | |
| 99 | Арга хэмжээ 2.4.7.2.1. Иргэдийг байнгын болон түр ажлын байраар хангаж ажиллана. | | Ажлын байраар хангасан хүний тоо | 2023 онд | Нийт 30-аас доошгүй хүнийг байнгын, 80-аас доошгүй хүнийг түр | 2024 оны жилийн эцсийн байдлаар Түр ажлын байранд 67 иргэн, Байнгын ажлын байранд – 32 иргэн, нийт 99 иргэнийг ажилд зуучилан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлын байраар хангасан байна. | ажлын байраар хангаж ажилласан байна. | |
| 100 | Арга хэмжээ 2.4.7.2.2. Иргэдийг мэргэжил олгох сургалтанд хамруулна. | | Сургалтанд хамрагдсан хүний тоо | 25 иргэн | 3-аас доошгүй төрлийн сургалтанд 30-аас доошгүй иргэдийг хамруулсан байна. | Төгсөх ангийн сурагчдад ирээдүйн мэргэжлээ зөв сонгох нь хамгийн чухал. Мэргэжил бүхэн өөрийн онцлоготой учраас төгсөх 32 ангийн сурагчдад мэргэжил бүрийн сайхныг танилцуулах зорилгоор суманд үйл ажиллагаагаа явуулдаг Засаг даргын Тамгын газар, Эрэн хайх аврах бүлэг, Эрүүл мэндийн төв, Цэцэрлэг, Соёлын төвийн үйл ажиллагаа бүтэц зохион байгуулалттай танилцууллаа. Хөдөлмөрт бэлтгэх сургалтыг зохион байгуулж, ажил олоход хүндрэлтэй иргэд болон Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа авдаг өрхүүд нийт 51 иргэн хамрагдсан.<br>3 иргэнийг няравын түргэвчилсэн сургалтанд үнэ төлбөргүй хамруулсан. | 100 |
| 101 | Арга хэмжээ 2.4.7.2.3. Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдэд хөнгөлттэй зээл олгоно. | | Хамрагдсан өрх, иргэний тоо | 2 иргэнд | 3-аас доошгүй иргэнийг хөнгөлттэй зээл, төсөлд хамруулсан байна. | 2024 онд ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, санхүүгийн дэмжлэг олгох төсөлд Гичгэнэ багийн ахмад настан Н.Баасанжав хамрагдаж 5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан. | 60 |
| 102 | Зорилт 2.4.7.3. Гэр бэлэглээ, Байшин төслүүдийг хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 103 | Арга хэмжээ 2.4.7.3.1. Орон гэр шаардлагатай өрхэд гэр олгоно. | 3000,0 | Олгосон гэрийн тоо | 1 өрхөд | 1-ээс доошгүй өрхөд гэр олгосон байна. | Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туссаны дагуу Засаг даргын Тамгын газрын 2024 оны төсвийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардалд “Гэр хөтөлбөр”-т 4.0 сая төгрөг төсөвлөж, Чулуут багийн 1 иргэнд 5 ханатай гэрийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гардуулж өгсөн. | |
| 104 | Арга хэмжээ 2.4.7.3.2. Шаардлагатай өрх, гэр бүлд түлээ, нүүрсний болон бусад дэмжлэг үзүүлнэ. | | Хамрагдсан өрхийн тоо | 22 иргэнд | 20-оос доошгүй өрхөд үзүүлсэн байна. | Засаг даргын Тамгын газрын 28 өрхийн 28 албан хаагч, тэдгээрийн гэр бүлд 1 тн нүүрсний дэмжлэг үзүүлж ажилласан. Мөн сумын Засаг даргын зүгээс амьжиргааны түвшнөөс доогуур болон тэтгэврээс өөр орлогогүй, тэтгэврийн мөнгө нь амьдрал ахуйд нь хүрэлцэхгүй байгаа Төвийн багийн 2 өрхөд тус бүрд нь 1 тн нүүрс олголоо. | 100 |
| 105 | **2.5 Соёл урлагийн чиглэлээр**<br>***Стратеги төлөвлөгөөний зорилго 2.5.3.Орон нутаг судлах танхимыг засварлаж, тохижуулна.*** | | | | | | |
| 106 | Зорилт 2.5.3.2. Орон нутаг судлах танхимын үзмэрийн тоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | | | | | | |
| 107 | Арга хэмжээ 2.5.3.2.1. Орон нутаг судлах танхимын үзмэрийн тоог нэмэгдүүлж дэглэлт хийнэ. | | Нэмэгдсэн үзмэрийн тоо | 2023 онд 120 үзмэр | Үзмэрийн тоог 5-р нэмэгдүүлнэ | Сумын Орон нутаг судлах танхимын үзмэрийн дэглэлтийг сүүлийн үеийн технологиор хийж, тайлбарлагч байхгүй үед гар утсаараа үзмэр болгоны хажууд байрлах QR кодыг уншуулан сонсох, унших цэснээс сонгон танилцах боломжтойгоор дэвшилтэт технологийг ашигласан бөгөөд 2024 онд нэмж 4 үзмэр дэлгэсэу бөгөөд нийт 124 үзмэртэй болсон байна. | 90 |
| 108 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 2.5.5. Хөгжмийн зохиолч Б.Шаравын нэрэмжит гэр урланг засварлаж, өргөтгөн тохижуулж, байнгын үйл ажиллагаатай болгоно*** | | | | | | |
| 109 | Зорилт 2.5.5.2. Гэр урлан, музейг байнгын ажиллагаатай болгоно. | | | | | | |
| 110 | Арга хэмжээ 2.5.5.2.1. Б.Шарав агсны гэр музейг ажиллуулж иргэд, жуулчдад таниулах ажлыг зохион байгуулна. | | Ажилласан өдрийн тоо, үйлчлүүлсэн жуулчид иргэдийн тоо | 2023 онд 30 хоног ажиллаж, 1500 иргэнд | 50-аас дээш хоног ажиллаж, 300-аас дээш жуулчид иргэдэд үйлчилнэ. | Хэнтий аймгийг аялал жуулчлалын бүс болон хөгжүүлж байгаатай холбогдуулан тус аймгийн түүхэн дурсгалт, байгалийн үзэсгэлэнт газраар аялах, зугаалахаар явж буй жуулчдад сурталчилан танилцуулах ажлыг зохион байгуулан Монгол | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улсын Хөдөлмөрийн баатар, Чингис хаан одонт, төрийн соёрхолт хөгжмийн зохиолч Бямбасүрэнгийн Шарав агсны гэр музейг 2024 оны 6 сарын 25-ны өдрөөс эхлэн 2024 оны 8 сарын 25-ны өдөр хүртэл ажлуулж нийт 318 иргэнд үйлчилсэн байна. | |
| 111 | **3. ЭДИЙН ЗАСАГ**<br>**3.1 Төсөв санхүү**<br>***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.1.1. Татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг нэмэгдүүлэх, орлогын төлөвлөлтийг сайжруулна.*** | | | | | | |
| 112 | Зорилт 3.1.1.1 Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг сар бүр, нэр төрлөөр нь бүрэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулна. | | | | | | |
| 113 | Арга хэмжээ 3.1.1.1.1. Орон нутгийн татварын орлогыг нэр төрлөөр нь жигд хангаж биелүүлнэ. | - | Татварын орлогын биелэлтийг хувиар | 2023 онд татварын орлогын төлөвлөгөө 96.5 хувиар биелсэн. | Орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлнэ. | 2024 онд орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 766.3 сая төгрөгөөр батлагдсанаас 12-р сарын 13-ны өдрийн байдлаар орон нутгийн татварын орлогод нийт 734.1 сая төгрөг төвлөрч, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 95,8 хувьтай биелээд байна. Төсвийн жилийн эцэс болох 2024 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал орон нутгийн татварын орлогод орлого төвлөрүүлэх ажил хийгдэж, орлогын төлөвлөгөөний биелэлтийг 100 хувьд хүргэх боломжтой. | 95 |
| 114 | Арга хэмжээ 3.1.1.1.2. АЗД СЗД-тай байгуулсан гэрээний төлөвлөлт, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн чиглэлээр хийж хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах | | Биелэлийн хувь, тайлагналтын хугацаа | 0 | Гэрээнд заасан хугацаагаар, биелэлтийн хувийг 80-аас дээш | Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээний хавсралтад заагдсан төлөвлөлт, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн чиглэлээр хийж хэрэгжүүлэх 8 арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаж, 83 хувьтай биелүүлж ажилласан. | 100 |
| 115 | Зорилт 3.1.1.2 Татварын бааз суурийг нэмэгдүүлэх, шинээр илрүүлэх ажлыг хэрэгжүүлнэ. | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 116 | Арга хэмжээ 3.1.1.2.1. Татварын орлогыг төлөвлөгөөг орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлд үндэслэн төвлөрүүлэх боломжтой дүнгээр бодитой төлөвлөж ИТХ-р батлуулж, улиралд бүр шинээр татвар төлөгчийг илрүүлж ажиллана. | | ИТХурал баталсан байна. | 2023 онд шинэ татвар төлөгч байхгүй. | Орлогын төлөвлөгөөг үндэслэн сумын төсвийг батлуулж, 8 татвар төлөгчийг шинээр илрүүлсэн байна. | 2024 оны төсөвт орлогын төлөвлөгөөг 766,3 сая төгрөгөөр сумын ИТХ-аар батлуулсан. 2024 онд шинээр 12 татвар төлөгч нэмэгдсэн байна. | 100 |
| 117 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.1.2.Татварын тайлагналт, хураалт, бүртгэлийг цахим тайлангийн системд 100 хувь хамруулан, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.*** | | | | | | |
| 118 | Зорилт 3.1.2.1 Татвар төлөгчийн тоог нэмэгдүүлж, татварын тайлагналт, хураалт, бүртгэлийг цахимжуулж, цахим тайлангийн системд 100% хамруулна. | | | | | | |
| 119 | Арга хэмжээ 3.1.2.1.1. Шинээр татвар төлөгчийг бүртгэж, татварын тайланг цахим тайлангийн системээр илгээх ажлыг сумын хэмжээнд зохион байгуулах | | Нэмэгдсэн татвар төлөгчийн тоо, цахим тайлангийн хувь | 1 аж ахуй нэг байгууллага, 10 малчинг татвар төлөгчөөр шинээр бүртгэж, цахим тайланг 100 хувь | 10 татвар төлөгч шинээр бүртгэх, цахим тайланг 100 хувьд хүргэх | 2024 оныг Хоршооны хөгжлийг дэмжих жил болгон зарласантай холбоотой шинээр 12 хоршоо байгуулагдаж татвар төлөгчөөр бүртгүүлсэн. | 100 |
| 120 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.1.3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлж, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудын өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулж, өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг хангаж ажиллана.*** | | | | | | |
| 121 | Зорилт 3.1.3.1 Төсөвт байгууллагуудын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд жил бүр хяналт тавьж ажиллана. | | | | | | |
| 122 | Арга хэмжээ 3.1.3.1.1. Төсөвт байгууллагууд хуулийн дагуу эд хөрөнгийн тооллого зохион байгуулсан эсэхэд хагас, бүтэн жилээр хяналт тавьж ажиллана. | | Хяналт шалгалтын тоо | 2023 онд 1 удаа хийсэн. | 2-с доошгүй удаа хяналт тавьж ажиллана. | Төсөвт байгууллагууд 2024 эхний хагас жилд сумын 6 төсөвт байгууллага эд хөрөнгийн тооллогыг хийж Санхүүгийн албанаас хяналт тавьж ажиллалаа. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх хугацаа болоогүй байна. Тооллого зохион байгуулагдах явцад Санхүүгийн албанаас хяналтын ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 95 |
| 123 | Зорилт 3.1.3.2 Байгууллагуудын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж, хяналт тавьж , гэрээний биелэлтйг хангуулж ажиллана. | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 124 | Арга хэмжээ 3.1.3.2.1. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилж, гэрээний биелэлтийг 85 дээш хувьд хүргэнэ | | Биелэлтийн хувийн өсөлт | 80.8 хувь | Өмч эзэмшлийн гэрээг 85 хувьтай дүгнүүлнэ. | “НЭГ ӨМЧ НЭГ БҮРТГЭЛ” аяны хүрээнд Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газраас ажлын хэсэг ирж сумын төсөвт байгууллагуудын эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт шалгалт хийж, өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэлээ. | 80 |
| 125 | Зорилт 3.1.3.3. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан " Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг хэрэгжүүлж ажиллана. | | | | | | |
| 126 | Арга хэмжээ 3.1.3.3.1. “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу хасах, бүртгэх хөрөнгийн материалыг бүрдүүлж ажиллах | | Журмын хэрэгжилтийн хувь | 0 | Журмын хэрэгжилтийг 90 хувь хангаж ажиллана. | Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, данснаас хасах, шилжүүлэх журмын дагуу эд хөрөнгө хасах, бүртгэх хөрөнгийн материалыг орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн ажиллаж байна. | 80 |
| 127 | Арга хэмжээ 3.1.3.3.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгах | | Бүртгэлд тусгасан хөрөнгийн тоо, хувь | 2023 онд 13 хөрөнгө бүртгэлд тусгасан. | Хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгана. | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлд Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар бүрэн тусгаж ажиллаж байна. | 100 |
| 128 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.1.4. Сум хөгжүүлэх болон жижиг дунд бизнесийг дэмжих сангуудыг нэгтгэн сангуудын эргэн төлөлтийг сайжруулж, авлагын 60 хувийг барагдуулах арга хэмжээг зохион байгуулна.*** | | | | | | |
| 129 | Зорилт 3.1.4.1. Хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, авлагыг бууруулна. | | | | | | |
| 130 | Арга хэмжээ 3.1.4.1.1. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулж, “Бусдад боломж олгоё” арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах | | Авлага төвлөрүүлэлтийн хувиар | 2023 онд 98.9 сая төгрөг төвлөрүүлсэн. | 2024 онд тус сангуудын авлагыг 60-с доошгүй хувиар багасгана. | 2024 оны 12 дугаар сарын 16-ны байдлаар Хоршоо хөгжүүлэх санд 32,282,212 төгрөгийн орлого буюу зээлийн эргэн төлөлт хийгдсэн байна. 2024 онд нийт 3 иргэн хугацаа хэтэрсэн зээлээ бүрэн төлж дуусгасан байна. | 80 |
| 131 | Арга хэмжээ 3.1.4.1.2 Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох ажлыг зохион байгуулна. | | Зээл олгосон хоршоо, ЖДҮЭ,иргэни | 1 иргэнд зээл олгосон. | 5-аас доошгүй а.а.н,иргэнд зээл олгосон байна | Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох, төсөл сонгон шалгаруулалтыг 2024 оны байдлаар 2 удаа зарласан боловч материал ирүүлсэн хоршоо | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | й тоо, олгосон төслийн хэмжээ | | | байхгүй байна. | |
| 132 | Арга хэмжээ 3.1.4.1.3. “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III”-ийг орон нутагт хэрэгжүүлж ажиллах | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | Төлөвлөгөөг 100 хувь боловсруулж батална. | “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III”-ийг 2024 онд орон нутагт хэрэгжүүлэх 3 зорилт, 9 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан сумын Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг 95 хувьтай ханган ажиллалаа. | 95 |
| 133 | Арга хэмжээ 3.1.4.1.4. Ахуйн үйлчилгээний өдөрлөг, үзэсгэлэн худалдааг сумын түвшинд зохион байгуулж “АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ-2024” өдөрлөгт ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг хамруулах | | Оролцсон иргэдийн тоо | 2023 онд 2 иргэн | 5-аас дээш иргэнийг оролцуулна. | “Жаргалтхаан суманд үйлдвэрлэв” намрын баяр арга хэмжээнд ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг оёдол, гар урлал, шир, суран эдлэлийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 5 иргэн оролцож, өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүдээ зарж борлуулж оролцсон. Мөн Хэнтий намрын баяр арга хэмжээнд оролцож, сумаа сурталчилсан. Аймгийн хэмжээнд “АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ” өдөрлөг зохион байгуулагдаагүй болно. | 100 |
| 134 | Арга хэмжээ 3.1.4.1.6. “Ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг сумын хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллах | | Төлөвлөгөөний боловсруулалтын хувь | 0 | Төлөвлөгөөг 100 хувь боловсруулж батална. | “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг 2024 онд орон нутагт хэрэгжүүлэх, төлөвлөгөө боловсруулан сумын Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллалаа. | 100 |
| 135 | Зорилт 3.1.4.2. Сангуудын зээлийн хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулж, хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулна. | | | | | | |
| 136 | Арга хэмжээ 3.1.4.2.1. Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналтыг сайжруулж ажиллах | | Хяналтын тоо | 2023 онд 1 удаа | 2-с дээш удаа зээлийн хэрэгжилтэд хянгалт тавина. | 2024 оны 11-р сард 2023 онд Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан 6 иргэний зээлийн төслийн хэрэгжилт, зээлийн төлөлтөд хяналт тавьж ажилласан. Сумын иргэдийн | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөөлөгчид шинээр сонгогдсонтой холбоотойгоор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хяналтын зөвлөлийн шинэ бүрэлдэхүүнийг хэлэлцүүлэхээр хүсэлт өгөөд байна. | |
| 137 | ***Стратегий төлөвлөгөөний зорилго 3.1.5. Худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулж, худалдан авах ажиллагааг 100 хувьд хүргэнэ.*** | | | | | | |
| 138 | Зорилт 3.1.5.1 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийн тендер шалгаруулалтыг 100 хувь цахимаар зохион байгуулах | | | | | | |
| 139 | Арга хэмжээ 3.1.5.1.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтыг хууль тогтоомжийн хүрээнд орон нутагт зохион байгуулж хэрэгжилтийг хангаж ажиллах, худалдан авах ажиллагааг ил тод шилэн болгож тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулах | - | Цахим худалдан авалтын тоогоор | 2023 онд 5 цахим худалдан авалт зохион байгуулсан. | 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зохион байгуулна. | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 27 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн байна. Үүнээс харьцуулалтын аргаар 6 төсөл арга хэмжээ, нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 1 төсөл арга хэмжээ, шууд худалдан авалтын 20 төсөл арга хэмжээ төлөвлөгдөж бүрэн зохион байгуулагдсан байна. | 100 |
| 140 | Арга хэмжээ 3.1.5.1.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн талаарх жилийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг сайжруулах | | Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний хувь | 2023 онд 76% | Жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 80 хувьд хүргэнэ. | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хэрэгжилтийн талаарх жилийн гүйцэтгэлийн үнэлгээ цахимаар хийгдэж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн программд 21 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг бүрэн оруулсан. | 90 |
| 141 | Арга хэмжээ 3.1.5.1.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг батлахдаа Төсвийн тухай хуулийн 60,3 дахь заалтад үндэслэж, орон нутгийн | | Санал өгсөн иргэдийн хувь | 2023 онд 55 хувь | Санал өгөх үйл ажиллагаанд иргэдийн 80-аас доошгүй хувийг хамруулна | 2025 онд Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгыг нийт 5 багийн 1026 иргэнээс авч саналыг нэгтсэн Багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн баталлаа. 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 550,3 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэдийн 80-аас доошгүй хувийн оролцоог хангах | | | | | төлөвлөн бүрэн хэрэгжиж байна. | |
| 142 | **3.2. Хөдөө аж ахуй** ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.2.1. Үр тариа, малын тэжээл тариалах, тэжээлийн үйлдвэр байгуулахыг дэмжиж ажиллана.*** | | | | | | |
| 143 | Зорилт 3.2.1.1. Атаршсан талбайг эргэлтэнд оруулж, төсөл сонгон шалгаруулалтаар олгосон 1500 га газарт үр тариа, тэжээлийн ургамал тариална. | | | | | | |
| 144 | Арга хэмжээ 3.2.1.1.1. Атаршсан талбайг эргэлтэнд оруулж, төсөл сонгон шалгаруулалтаар олгосон 1500 га газарт үр тариа, тэжээлийн ургамал тариална. | | Тариалсан талбайн хэмжээ | 1500 га-д тариалсан. | 1500-с доошгүй га-д тарилна. | 2022 онд төсөл сонгон шалгаруулалтаар “ЭБЭГ” ХХК-нд 1500га мөн ЗДТГазрын эзэмшлийн 200га талбайг эргэлтэд оруулж, 2024 онд нийт 900га талбайд малын ногоон тэжээл тариалж малчдад хөнгөлөлттэй үнээр олгоод байна. | 70 |
| 145 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.2.2. Малчдын орлогыг хадгалах зорилгоор тэжээлийн ургамал тариалж, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх , хөнгөлттэй үнээр олгох ажлыг зохион байгуулна.*** | | | | | | |
| 146 | Зорилт 3.2.2.1. Малчдын хэрэгцээнд зориулж баг бүрийн нутаг дэвсгэрт ногоон тэжээл тариалж, хөнгөлттэй үнээр олгоно. | | | | | | |
| 147 | Арга хэмжээ 3.2.2.1.1. 200 га-д шинээр малын тэжээлийн ургамал тариалж, малчдад хөнгөлттэй үнээр олгоно. | | Хөнгөлттэй үнээр олгосон тэжээлийн хэмжээ | 40 тн тэжээл хөнгөлөлттэй үнээр олгосон. | 2024 онд 40-өөс дээш тн тэжээл хөнгөлөлттэй үнээр олгоно. | Засаг даргын Тамгын газрын эзэмшлийн 200 га атаршсан талбайг эргэлтэд оруулж, 2024 онд тариалалт хийж, намар 625 тн ургац хураан авч малчдад хөнгөлөлттэй үнээр олгоод байна. | 100 |
| 148 | Зорилт 3.2.2.2. Сумын өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлнэ. | | | | | | |
| 149 | Арга хэмжээ 3.2.2.2.1. Өвөлжилтийн бэлтгэлийг хангаж байгалийн хадлан, гар тэжээл бэлтгэнэ. | | Бэлтгэсэн өвс, хадлан тэжээлийн хэмжээгээр | 2023 онд хадлан 2000 тонн, гар тэжээл 40 тонн бэлтгэсэн. | Хадлан 2000 тонн, гар тэжээл 50 тонноос доошгүйг бэлтгэсэн байна. | Мал аж ахуйн салбарын 2024-2025 онд өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2024 оны намар малчид байгалийн хадлан 2000тн, 10 тн гар тэжээл бэлтгэж аймгийн Засаг даргын өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг хангах тухай албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллалаа. | 98 |
| 150 | Арга хэмжээ 3.2.2.2.2 Сумын аюулгүй нөөцөд өвс, ногоон | | Нөөцийн төлөвлөгөөни | 100 тн өвс, 40 тн тэжээл нөөцөлсөн. | Нөөцийн төлөвлөгөөг 90-ээс дээш хувьд хүргэнэ. | Сумын Засаг даргын Тамгын газрын 200 га талбайд малын ногоон тэжээл тариалж, түүнээс 1600 боодол буюу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэжээл нөөцлөнө. | | й биелэлтийн хувь | | | 40тн малын ногоон тэжээл, суманд үйл ажиллагаа явуулж байгаа “ЭБЭГ” ХХК-тай гэрээ байгуулж, сумын аюулгүйн нөөцөд Дорнод аймгаас 4000 боодол буюу 100 тн нарийн ногоон өвсийг татан авчирч сумын өвсний фондны хашаанд байршуулан сумын аюулгүйн нөөцөд өвс, ногоон тэжээлийг бэлтгэж аймгийн Засаг даргын өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг хангах тухай 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг 100 хувь хангаж ажиллалаа. | |
| 151 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.2.3. Өрхийн тариалалт, төмс хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийг дэмжиж, хүлэмж , агуулах, зоорийг шинээр барьж байгуулна.*** | | | | | | |
| 152 | Зорилт 3.2.3.1. Өрх бүр хашаандаа төмс, хүнсний ногоо тариалахад дэмжлэг үзүүлж ажиллана. | | | | | | |
| 153 | Арга хэмжээ 3.2.3.1.1. Өрх бүр хашаандаа төмс, хүнсний ногоо тариалахад дэмжлэг үзүүлэн ногооны үр олгож тариалан эрхлэгчдийг дэмжих, ургац хураалтыг нэмэгдүүлэх | | Дэмжлэг үзүүлсэн тариаланчийн тоо, ургац хураалтын хувь | 2023 онд 47 иргэнд төмс хүнсний ногооны үр хөнгөлөлттэй үнээр олгосон. Ургац хураалт 11.2 хувь | 45-аас доошгүй иргэнд дэмжлэг үзүүлж, ургац хураалтыг 5 хувиар нэмэдүүлнэ. | 2024 оны хавар Хэнтий аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас нарийн ногооны үр үнэгүй олгосон. Мөн сумын хүлэмжийн аж ахуйтай хамтран гала сортын төмсний үрийг иргэдэд хямдралтай үнээр олгож, 2024 онд төмс 8,5 га талбайд тариалж 89 тн, хүнсний ногоо 6,2 га талбайд тариалж 39,05 тн ургац хураан аваад байна. Энэ нь өмнөх оны тариалалт, ургац хураалттай харьцуулахад 4.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | 90 |
| 154 | Зорилт 3.2.3.2. Хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалт, хүлэмж, зоорийн аж ахуй эрхлэхэд хөнгөлттэй зээлийн бодлогоор дэмжлэг үзүүлнэ. | | | | | | |
| 155 | Арга хэмжээ 3.2.3.2.1 Хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалт, хүлэмж, зоорийн аж ахуй эрхлэхэд хөнгөлттэй зээлийн бодлогоор дэмжиж зээл хамруулж ажиллана. | | Зээлд хамрагдсан иргэдийн тоо | 2023 онд 1 иргэн | 2-с доошгүй иргэнийг зээл хамруулна. | 2024 оны 5 сард 50 иргэнд хүнсний нарийн ногооны үрийг үнэгүй олгож, 10 иргэнд 1 га талбай бүхий төмс хүнсний ногоо тариалах хашаажуулсан талбайг хүлээлгэн өгч тариалалтыг бүрэн хийлгэж, ургац бүрэн хураан авч дэмжлэг үзүүлээд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна. | |
| 156 | Зорилт 3.2.3.4. Стандартын шаардлага хангасан 50 тн-ын багтаамжтай хүнсний ногооны зоорь барина. | | | | | | |
| 157 | Арга хэмжээ 3.2.3.4.1. Зоорийн зураг төсвийг хийлгэх ажлыг хийж хэрэгжүүлнэ. | | Зураг төсвийн гүйцэтгэлийн хувь | 0 | Зураг төсвийг 100 хувь хийлгэсэн байна. | Зоорь байгуулах иргэн, ААНэгжийн хүсэлт ирээгүй болно. | 0 |
| 158 | Зорилт 3.2.3.5.Төмс, хүнсний ногооны тариалалт, үйлдвэрлэлд ашиглах тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 159 | Арга хэмжээ 3.2.3.5.1. Төмс, хүнсний ногоо тариалахад шаардлагатай тоног төхөрөмж худалдаж авна. | 40000.0 | Худалдаж авсан тоног төхөөрөмжийн тоо | 2023 онд 3 тоног төхөөрөмж | 1 тоног төхөөрөмж худалдаж авна. | Монгол Улсын Засгийн газраас Засаг даргын Тамгын газарт иргэдийн төмс, хүнсний ногоо тариалахад нь зориулж нийт 48.8 сая төгрөгийн өртөгтэй бага оврын трактор 1, бутлагч борной 1, нарийн ногооны үрлэгч зэрэг 3 тоног төхөөрөмж олгосон бөгөөд эдгээр тоног төхөөрөмжүүдийг 2024 онд иргэдэд төмс, хүнсний ногоо тариалах, хураах ажилд бүрэн ашиглуулсан. | 100 |
| 160 | Зорилт 3.2.3.3. Хүнсний ногоо, газар тариалан эрхлэгчдэд зориулсан сургалт, зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулна. | | | | | | |
| 161 | Арга хэмжээ 3.2.3.3.1 Хүнсний ногоо, газар тариалан эрхлэгчдэд зориулсан сургалт, зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулна. | | Сургалт, зөвөлгөөний тоо, хамрагдсан иргэдийн тоо | 2023 онд 2 сургалтад 25 иргэн хамруулсан. | 1 удаа зохион байгуулж, 20-с доошгүй иргэнийг хамруулна. | 2024 оны 5-р сард хүлэмжийн тариалалт хийх сургалтад хүлэмжийн аж ахуй эрхлэх сонирхолтой 10 иргэнийг хамруулж, тариалалт хийх заавар, анхаарах асуудлаар сургалт хийсэн. | 75 |
| 162 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.2.4.Бэлчээрийн хамгаалалт, ашиглалтыг сайжруулах зорилгоор Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаан Бэлчээр ажиглалтын журам боловсруулж, мөрдүүлж ажиллана.*** | | | | | | |
| 163 | Зорилт 3.2.4.1. Сумын хэмжээнд баг тус бүрээр бэлчээр менежментийн төлөвлөгөө, журам боловсруулж, мөрдүүлнэ. | | | | | | |
| 164 | Арга хэмжээ 3.2.4.1.1. Бэлчээр ашиглалтын журам боловсруулж, батлуулан мөрдүүлж ажиллах | | Хэрэгжилтийн хувь | 0 | Журам боловсруулж, ИТХ-р батлуулна | Сумын Засаг даргын 2024 оны 02 сарын 20-ны өдрийн А/28 тоот захирамжаар сумын “Бэлчээр ашиглалтын журам боловсруулах” | 60 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлын хэсэг байгуулагдан журам боловсруулж, багийн иргэдийн нийтийн хурал болон малчдын чуулга уулзалтаар малчид иргэдэд танилцуулж, багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэцүүлсэн. 2024 оны 12 сарын 26-ны өдөр хуралдах сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулаад байна. | |
| 165 | Зорилт 3.2.4.2. Үлийн цагаан оготно устгалын ажлыг зохион байгуулна. | | | | | | |
| 166 | Арга хэмжээ 3.2.4.2.1. Малчид, иргэдтэй хамтран үлийн цагаан оготно ихээр төвлөрсөн газрын судалгаа хийж, устгал хийх ажлыг хийж хэрэгжүүлнэ. | | Устгал хийсэн талбайн хэмжээ | 2023 онд 5000 га | 8000 га-аас доошгүй талбайд устгал хийнэ. | 2024 онд Улсын төсвийн 11,8 сая төгрөгийн хөрөнгөөр Гичгэнэ багийн нарийн, Баянцогт багийн Номгоны хөндийд 8500 га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготно устгалыг энгийн механик биологийн аргаар устгах ажлыг амжилттай зохион байгууллаа. | 100 |
| 167 | Зорилт 3.2.4.3. Бэлчээрээ хамгаалах, зүй зохистой ашиглах талаар малчдыг мэдээллээр хангах, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулна. | | | | | | |
| 168 | Арга хэмжээ 3.2.4.3.1. Малчдад бэлчээр ашиглалтын талаар сургалт, сурталчилгаа хийнэ. | | Сургалтын тоо, хамрагдсан малчдын хувь | 1 удаа сургалт, нийт малчдын 30 хувийг хамруулсан. | Жилд 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулж, нийт малчдын 90-ээс доошгүй хувьд сургалт, сурталчилгаа хийсэн байна. | 5 багийн Иргэдийн Нийтийн Хурлын хуралд оролцогч малчдад иргэдэд бэлчээр ашиглалтын талаар мэдээ мэдээлэл хүргэн, сурталчилж ажиллалаа. Тус арга хэмжээнд 5 багийн 252 малчин хамрагдлаа. | 80 |
| 169 | Арга хэмжээ 3.2.4.3.2. Монгол улсын Засгийн газрын 2019 оны 185 дугаар тогтоолыг хэрэгжүүлж “Бэлчээр хамгаалах өдөр”-ийг сум багийн түвшинд зохион | | Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан иргэдийн тоо | 2023 онд 1 арга хэмжээ, 173 иргэн | 2-оос доошгүй арга хэмжээнд 400-аас доошгүй иргэдийн хамруулна. | Монгол улсын Засгийн газрын 2019 оны 185 дугаар тогтоолыг хэрэгжүүлж “Бэлчээр хамгаалах өдөр”-ийг сум багийн түвшинд зохион байгуулах ажлын хүрээнд 5-р сард зохион байгуулагдсан Багийн Иргэдийн Нийтийн Хурал, Мал аж ахуйн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах | | | | | үйлдвэрлэл эрхлэгчдийн XI чуулга уулзалтад оролцогч малчдад тус тогтоол болон бэлчээр ашиглах журмын төслийг танилцуулж, санал хүсэлтийг нь тусгаж ажиллалаа. Тус арга хэмжээнд давхардсан тоогоор 452 малчин хамрагдлаа. | |
| 170 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.2.5.Худаг шинээр гаргах, сэргээн засварлах зэргээр бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.*** | | | | | | |
| 171 | Зорилт 3.2.5.1. Худаг шинээр гаргах, сэргээн засварлах зэргээр бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | | | | | | |
| 172 | Арга хэмжээ 3.2.5.1.1. Худаг шинээр гаргах, сэргээн засварлах зэргээр бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | 48000,0 | Гаргасан худгийн тоо | 2023 онд 6 худаг | 4-ээс доошгүй гүн өрмийн худаг гаргана. | 2024 онд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах чиглэлээр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 11.0 сая төгрөгийн хөрөнгөөр 2 гүн өрмийн худаг сэргээн засварлаж, малчдад эзэмшүүлээд байна. Мөн Чулуут багийн 1 малчин өөрийн хөрөнгөөр бэлчээрт гүн өрмийн худгийг шинээр гаргасан. | 80 |
| 173 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.2.6. Малын тоог чанарт шилжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж,“ Монгол мал-II ” арга хэмжээг хэрэгжүүлнэ.*** | | | | | | |
| 174 | Зорилт 3.2.6.1. Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан үе шаттай хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 175 | Арга хэмжээ 3.2.6.1.1. “ Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан гаргаж, хэрэгжүүлж ажиллах | | Хэрэгжилтийн хувиар | 2023 онд төлөвлөгөөний хэрэгжилт 92 хувьтай | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 92.5 хувьд хүргэнэ | “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг хагас бүтэн жилээр гаргаж, ХХААГазарт хүргүүлж ажиллалаа. Монгол малчин үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг 90 хувьтай дүгнүүлсэн. | 90 |
| 176 | Арга хэмжээ 3.2.6.1.2. Мал аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, | | Хамрагдсан өрх, малчдын тоо | 2023 онд 120 малчин өрх, 202 малчинд мэдээлэл | Мэдээлэл авсан өрх, малчдын тоог өмнөх оноос 15-р нэмэгдүүлэх. | “Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн 11-р чуулга уулзалт”-ыг зохион байгуулж малчдад төрийн бодлого, шийдвэрийг таниулах, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бодлого шийдвэрийг малчид, иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулах | | | хүргэсэн | | шаардлагатай сургалт мэдээллийг хүргэх, тэдний санал бодлыг сонсох, гаргасан саналыг дараагийн үйл ажиллагаа, бодлогын баримт бичигт тусгах жлыг зохилон байгуулсан. Тус арга хэмжээнд 126 малчин өрхийн 200 малчин оролцсон. | |
| 177 | Арга хэмжээ 3.2.6.1.3. ХХААХҮЯ-ны харьяа Тариалан эрхлэх сангаас хөнгөлөлттэй үнээр олгосон хөрөнгийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах | | Сангийн эргэн төлөлтийн дүнгээр | 2023 онд эргэн төлөлтөд 0 сая төгрөг төвлөрүүлсэн. | Эргэн төлөлтийн үлдэгдэл 2,3 сая төгрөгийн төвлөрүүлж дууссан байна. | Тариалан эрхлэлтйг дэмжих сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэй тулгалт хийж, тариалан эрхлэх сангаас хөнгөлөлттэй үнээр авсан тракторын төлбөр тооцоог хийж дутуу төлөлттэй байгаа иргэдтэй уулзаж, 1,064,000 төгрөгийн төлбөр тооцоог барагдуулж ажиллалаа. | 80 |
| 178 | Арга хэмжээ 3.2.6.1.4. Малыг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд баяжилт хийх ажлыг зохион байгуулах | - | Ялган тэмдэглэж, бүртгэлжүүлсэн малын тоо | 402 толгой малыг эзэмгжүүлж бүртгэлжүүлсэн | Бүртгэлжилтийн тоог 50-р нэмэгдүүлнэ. | Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд баяжилт хийж, 512 малчдын малын мэдээллийг шинэчилж, 2024 оны хорогдол, төлийг бүрэн шивж оруулсан. | 100 |
| 169 | Арга хэмжээ 3.2.6.1.5. Бог малын хээлтүүлэгчийг Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад шилжүүлж ялган төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах | - | Ялган төвлрүүлсэн хээлтүүлэгчийн хувь | 2023 онд 1060 толгой мал хамруулсан 0 | Нийт хээлтүүлэгчийн 95-аас доошгүй хувийг ялгана. | Суманд мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж байхгүй. 2024 онд 4 малчин өрхөд хуц, ухны сүүрийг ялган төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан. | 60 |
| 180 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.2.7.Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хяналтын тогтолцоог сайжруулж, малын гаралтай халдварт, гоц халдварт өвчний гаралтыг бууруулна.*** | | | | | | |
| 181 | Зорилт 3.2.7.1. Мал эмнэлгийн аж ахуйн нэгжүүдийг чадавхижуулах, хүний нөөц, тоног төхөөрөмжийн хангалт, эмчилгээ, үйлчилгээний чанарыг сайжруулна. | | | | | | |
| 182 | Арга хэмжээ 3.2.7.1.1 Мал эмнэлгийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, жилийн эцэст | | Жилдээ 2-оос доошгүй удаа хяналт тавьсан | 1 удаа | Малчдаас санал асуулга авах, үйл ажиллагаанд нь хяналт шалгалт | Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай" захирамж, Бруцеллёз өвчнөөс урьдчилан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлан тавиулж ажиллах | | байна. | | хийх замаар хяналт тавина. | сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд мал эмнэлгийн нэгжүүдийн үйл ажиллагаанд малчин өрхүүдээс асуумж авах, малын эрүүл мэндийн дэвтэрт шалгалт хийх замаар хяналт тавьж ажиллалаа. | |
| 183 | Арга хэмжээ 3.2.7.1.2. Мал эмнэлгийн талаар хэрэгжүүлж буй хууль тогтоомж, бодлого шийдвэр, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж сэрэмжлүүлгийг малчид иргэдэд хүргэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах | | Зохион байгуулсан сургалт сурталчилгаа ны тоо, хамрагдсан иргэдийн тоо | 1 удаа 150 иргэн | Жилд 2-оос доошгүй удаа сургалт, сурталчилгаа зохион байгуулж, 500-аас доошгүй иргэн хамруулна. | “Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн XI чуулга уулзалт” зохион байгуулагдлаа. Зөвлөгөөнд “Мэргэн жонон” мал эмнэлгийн малын эмч Ц.Ганбат оролцож, малчдын асуулт хариулт болон өдөр тутамд тулгамддаг малын өвчлөлийн талаар мэдээлэл солилцлоо. Малчид, иргэдийг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 13 төрлийн цаасан брошур, гоц халдварт өвчний цахим брошур бэлтгэж, багийн Иргэдийн нийтийн хурал, Малчдын зөвлөгөөн, тандалтын үеэр нийт 482 ширхэгийг тарааж сурталчиллаа. Мөн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсанд мэдээлэл бэлтгэн байршуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. | 90 |
| 184 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.2.8.Хүн амыг эрүүл аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангахад төр, хувийн хэвшил, иргэний хамтын ажиллагаа, хяналтыг сайжруулахад анхаарч ажиллана.*** | | | | | | |
| 185 | Зорилт 3.2.8.1 Хүн амыг эрүүл аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр эрүүл ахуйн чанарын шаардлага хангасан мах, сүү, гурилан бүтээгдэхүүн, хүнсний ногоог сумандаа үйлдвэрлэхийг бүх талаар дэмжиж ажиллана. | | | | | | |
| 186 | Арга хэмжээ 3.2.8.1.1. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулна | | Хөнгөлттэй зээлд хамрагдсан үйлдвэрлэгчд ийн тоо | 2023 онд 1 иргэн | 2-аас доошгүй ЖДҮ эрхлэгчид хөнгөлттэй зээл олгосон байна. | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, гарааны бизнес эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт Гичгэнэ багийн иргэн Ж.Сайнгэрэл оёдлын “Уран үйл” төслөөр 10.0 сая төгрөгийн хүүгүй зээлд хамрагдсан байна.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Гичгэнэ багийн ахмад настан Н.Баасанжав “Төмөр эдлэл” яндан хийх, дугуй засварын чиглэлээр 5 сая төгрөгийн хүүгүй зээлд хамрагдсан байна. | |
| 187 | Зорилт 3.2.8.2. Хүнсний аюулгүй байдлын талаар сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулна. | | | | | | |
| 188 | Арга хэмжээ 3.2.8.2.1. Хүнсний аюулгүй байдлын талаар сургалт сурталчилгааны соён гэгээрүүлэх ажлыг мэдээллийн хэрэгсэл ашиглан зохион байгуулах | | Сурталчилгааны тоо | 2023 онд 10 удаа | Сар бүр 2-оос доошгүй | Хүнсний аюулгүй байдлын талаар сургалт сурталчилгааны соён гэгээрүүлэх ажлыг Жаргалтхаан ЗДТГ-ын фэйсбүүк хуудсаар сар бүр цуврал мэдээлэл болгон хүргэн ажилласан. Нийт 13 мэдээлэл бэлтгэж хүргэсэн байна. | 100 |
| 189 | Арга хэмжээ 3.2.8.2.2. Мэргэжлийн байгууллагатай хамтран хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт танхимын сургалт зохион байгуулна | | Хамрагдалтын хувь | 0 | Нийт хүнсний худалдаа эрхлэгчдийн 30-аас доошгүй хувийг хамруулсан байна. | Хүнс хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанар, стандартын улсын байцаагч Б.Саранчимэг хүнсний худалдаа эрхлэгчид болон хоол үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй 25 иргэнд байгууллагын дотоод хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулсан. | 100 |
| 190 | Зорилт 3.2.8.3. Хүнс, нийтийн хоолны салбарын үйл ажиллагаа эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулна. | | | | | | |
| 191 | Арга хэмжээ 3.2.8.3.1. Хүнсний худалдаа, нийтийн хоолны үйл ажиллагаа эрхлэгчдэд чадавхжуулах сургалт зохион байгуулж, бусад газраас зохион байгуулсан сургалтад хамруулна. | | Сургалт, оролцсон иргэн аж ахуйн нэгжийн тоогоор | 2 удаа 15 | 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулж, 15-аас дээш хүн сургалтад хамруулна. | Хэнтий аймагт зохион байгуулсан ур чадварын сургалтад Ерөнхий боловсролын сургуулийн болон цэцэрлэгийн 2 тогоочийг хамруулсан. Хүнсний худалдаа, нийтийн хоолны үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулан Хүнс хөдөө аж ахуйн газраас зохион байгуулсан цахим сургалтад үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч 15 иргэнийг хамруулсан байна. | 100 |
| 192 | Зорилт 3.2.8.4. Хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана. | | | | | | |
| 193 | Арга хэмжээ 3.2.8.4.1. Нийтийн хоол үйлдвэрлэл, хүнсний | | Хяналт шалгалт | 3 удаа | Улирал бүр 1 удаа | 2024 оны 2, 6, 9, 12-р сарууддад хүнсний худалдаа эрхлэгч болон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | худалдаанд тавих хяналтыг сайжруулна. | | хийсэн тоо | | | нийтийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудад хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, заавар зөвлөмж хүргэж ажиллалаа. | |
| 194 | Арга хэмжээ 3.2.8.4.2. Сургуулийн дотуур байр, үдийн хоол, Цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлд тавих хяналтыг сайжруулна | | Хяналт шалгалтын тоо | 3 удаа | Хүүхдийн хоол хүнсний чанар сайжирна. | Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол хөтөлбөрт хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй хамтран жилд 3 удаа хяналт шалгалт хийж, заавар зөвлөмж хүргэж ажиллалаа.<br>Цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг улирлын хяналтын хөтөлбөрт хамруулж хяналт шалгалт хийж, заавар зөвлөмж хүргэж ажиллалаа. | 100 |
| 195 | Зорилт 3.2.8.5. "Намрын ногоон өдрүүд", "Цагаан сар-Цагаан идээ" үзэсгэлэн худалдаанд үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулна. | | | | | | |
| 196 | Арга хэмжээ 3.2.8.5.1. “Цагаан сар-Цагаан идээ”, “Намрын баяр” “ Намрын ногоон өдрүүд” арга хэмжээг суманд зохион байгуулж шалгарсан оролцогчдыг дараагийн шатанд оролцуулах | | Зохион байгуулсан арга хэмжээ, оролцсон оролцогчдын тоо | 2 арга хэмжээ, 7 иргэн | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 20-аас доошгүй иргэн оролцуулна. | “Хэнтий цагаан сар8 цагаан идээ-2024” арга хэмжээ 01 сарын 29-нд зохион байгуулагдаж сумаас 6 иргэн сүү цагаан идээ, айраг, талх, нарийн боов, монгол гутал, дээл, бүс, цамц зэрэг үйлдвэрлэлийн чиглэлээр оролцсон байна.<br>"Жаргалтхаан намрын баяр-2024" үзэсгэлэн худалдаа 09 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулагдаж, 24 иргэн оролцож нийт 3850.0 мянган төгрөгийн борлуулалт хийсэн байна.<br>“Хэнтий намрын баяр” нэгдсэн арга хэмжээнд 9 үйлдвэрлэгч оролцож, нийт 4.670.0 мянган төгрөгийн борлуулалт хийгдсэн бөгөөд "Эрүүл хүнс-2024" үзэсгэлэн худалдаанд "Шилдэг гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”-ээр Баянцогт багийн үйлдвэрлэгч Б.Пүрэвжав шалгарсан. | 85 |
| 197 | Зорилт 3.2.8.7. Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлттэй зээлийн бодлогоор дэмжиж ажиллана. | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 198 | Арга хэмжээ 3.2.8.7.1. Хүнсний үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг зээлд хамруулна. | | Аж ахуй нэгж, иргэний тоо | 0 | 3-с доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг зээлд хамруулна. | Зээл хүссэн үйлдвэрлэл эрхлэгч байхгүй болно. | 0 |
| 199 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.2.9.Уламжлалт нүүдлийн мал аж ахуйн өв соёлыг хадгалж хамгаалах, залуу малчдад өвлүүлэх арга хэмжээ зохион байгуулна.*** | | | | | | |
| 200 | Зорилт 3.2.9.1. Малчдын чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулна. | | | | | | |
| 201 | Арга хэмжээ 3.2.9.1.1. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн чуулга уулзалт зохион байгуулна. | 1500,0 | Малчдын хамрагдалтын хувь | 2022 онд 200 малчин хамруулсан. | Нийт малчдын 30-с дээш хувийг хамруулна | “Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн 11-р чуулга уулзалт”-ыг малчдад төрийн бодлого, шийдвэрийг таниулах, шаардлагатай сургалт мэдээллийг хүргэх, тэдний санал бодлыг сонсох зорилгоор 06-р сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Чуулга уулзалтад нийт малчдын 27.9 % буюу 200 малчин оролцлоо. | 100 |
| 202 | Зорилт 3.2.9.2. Адуучин тэмцээнийг жил бүр зохион байгуулна. | | | | | | |
| 203 | Арга хэмжээ 3.2.9.2.1. Төвийн багтай хамтран сумын аварга шалгаруулах адуучин тэмцээнийг зохион байгуулна. | | Хамрагдсан адуучдын тоо | 2023 онд зохион байгуулаагүй. | 50 хүртэл адуучдыг хамруулна. | Сумын аварга шалгаруулах Адуучин тэмцээнийг 2024 оны 08 дугаар сарын 11-ний өдөр Гичгэнэ багийн Хар нуурт амжилттай зохион байгуулж, 43 адуучин оролцсон.<br>Мөн Хэнтий аймгийн аварга адуучин тэмцээнийг Гичгэнэ багийн Хар нуурт амжилттай зохион байгуулсан. | 100 |
| 204 | Зорилт 3.2.9.3. Мал маллах уламжлалт арга ухааныг залуу малчдад түгээх, өвлүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулна. / техникээр биш мориор малаа хариулах, бэлчээрээ сэлгэх/ | | | | | | |
| 205 | Арга хэмжээ 3.2.9.3.1. Мал маллах арга ухааны талаар мэдээлэл, зөвлөмж бэлтгэн залуу малчдад хүргэх ажлыг зохион байгуулах/ цахим болон цаасаар/ | | Малчдын хамрагдалтын хувь | 0 | Малчдын 50-аас доошгүй хувийг хамруулах | “Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн 11-р чуулга уулзалт”-ын үеэр мал маллах арга ухааны талаар мэдээлэл, зөвлөмж бэлтгэн залуу малчдад хүргэж ажиллалаа. Тус арга хэмжээ 200 малчин оролцлоо. | 60 |
| 206 | ***Стратегийн төлөвлөгөний зорилго 3.2.10.Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүд болон үйлчилгээний газрууд байгуулахыг дэмжиж ажиллана.*** | | | | | | |
| 207 | Зорилт 3.2.10.1. Мах, сүү, ноос, арьс шир боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулахад хөнгөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ. | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 208 | Арга хэмжээ 3.2.10.1.1. Малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлттэй зээл олгоно. | | Зээлд хамрагдсан иргэн, ААН-ийн тоо | 0 | 2-оос доошгүй | Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд хөнгөлөлттэй зээлд 14 хоршооны 20 малчин өрх хамрагдаж, нийт 897,800,000 төгрөгийн зээл аваад байна. | 100 |
| 209 | ***Стратегийн төлөвлөгөөний зорилго 3.2.12. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг дэмжих зорилгоор " Малжуулах" арга хэмжээ хэрэгжүүлнэ.*** | | | | | | |
| 210 | Зорилт 3.2.12.1. Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан үе шаттай хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 211 | Арга хэмжээ 3.2.12.1.1. Малгүй, цөөн малтай иргэдийг малжуулах хөтөлбөрт хамруулна. | | Хамрагдсан иргэний тоо, олгосон малын тоо | 2023 онд 7 иргэн, 382 толгой мал | 5-аас доошгүй иргэнийг 150-аас доошгүй малаар малжуулсан байна. | Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас малгүй малчин өрхийг малжуулах хөтөлбөрт 17 өрхийг 8 сая төгрөгийн санхүүжилттэй нийт 136 сая төгрөгийн малжуулах арга хэмжээнд хамруулсан байна. | 100 |
| 212 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.2.13. Орон нутагт үйлдвэрлэж буй сумын брэнд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан худалдааны нэгдсэн төв байгуулна.*** | | | | | | |
| 213 | Зорилт 3.2.13.1 Орон нутагт үйлдвэрлэж буй сумын брэнд бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, мах махан бүтээгдэхүүн, гурилан бүтээгдэхүүн, сүү цагаан идээ, хүнсний ногоо зэргийг сумын брэнд болгон хаяг шошготой болгож ажиллана. | | | | | | |
| 214 | Арга хэмжээ 3.2.13.1.1. Сумын хэмжээнд уламжлалт технологийг ашиглан брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, хөгжүүлэх | | Брэнд бүтээгдэхүүний тоо | 3 бүтээгдэхүүн | 2-оос доошгүй брэнд бүтээгдэхүүн бий болгоно. | Чулуут багийн иргэн А.Баяржаргал, Төвийн багийн иргэн Д.Мөнхцэцэг нар малын өөхийг ашиглан химийн орц найрлагагүй, эрүүл эко саван үйлдвэрлэж сумын иргэдийн хэрэгцээг хангаж сумын “Брэнд” бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлээд байна. Мөн намрын баяр үзэсгэлэн худалдаанд оролцож шилдэг үйлдвэрлэгч иргэдээр шалгарсан байна. | 100 |
| 215 | Арга хэмжээ 3.2.13.1.2. Худалдаалагдаж буй брэнд бүтээгдэхүүнийг хосолсон бичвэр бүхий хаяг шошготой болгох ажлыг эрчимжүүлнэ | | Шошготой болсон бүтээгдэхүүний тоо | 3 бүтээгдэхүүн | 2-оос доошгүй шинэ бүтээгдэхүүнийг шошготой болгоно. | Шинээр үйлдвэрлэгдэж буй эко саван, давсан урлалын бүтээгдэхүүнүүдийг хосолсон хаяг шошготой болгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 216 | **3.3. Аялал жуулчлал**<br>***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.3.1. Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрутын дагуу түр буудаллах цэг, мэдээлэл, үйлчилгээний төвийг байгуулна.*** | | | | | | |
| 217 | Зорилт 3.3.1.1. Түр буудаллах цэг, мэдээлэл лавлагааны төв байгуулна. | | | | | | |
| 218 | Арга хэмжээ 3.3.1.1.1. Түр буудаллах цэгийн үйл ажиллагааг тогтмолжуулж аялал жуулчлалаар явж буй иргэдэд тав тухтай үйлчилгээ үзүүлэх | | Үйлчлүүлсэн иргэдийн тоо | 0 | Сард 150-аас доошгүй аялагч нарт үйлчилгээ үзүүлнэ. | MCS группын охин компани "ИСУН МОД ТУР" ХХК нь сумын мянганы зам дагуу "ӨРТӨӨ 240" түр буудаллах цэг, ариун цэврийн байгууламж, хүнсний дэлгүүр, түргэн хоол, душ зэрэг цогц үйлчилгээний газрыг өөрийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулсан.<br>Ариун цэврийн өрөөнүүдийн хувьд эрэгтэй, эмэгтэй нойлтойгоос гадна, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жирэмсэн, хүүхдүүдэд зориулсан 00-той. Гадна талдаа трестай, хог ангилах хогийн жишиг сав, хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэх боломжтой шат зэргийг шийдэж өгсөн нь орон нутагт жишиг тогтохуйц бүтээн байгуулалт болсон. Тус газраар 2024 онд нийт 5216 иргэн үйлчлүүлсэн байна. | 100 |
| 219 | ***Стратеги төлөвлөгөөний зорилго 3.3.2. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад дотоодын жуулчдыг татах, орон нутаг, өв соёлоо сурталчлах зорилгоор эвент арга хэмжээг зохион байгуулна.*** | | | | | | |
| 220 | Зорилт 3.3.2.1. Нутгийн брэнд, эко бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгчид, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний ажилтнуудыг чадавхижуулах сургалтанд хамруулж, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэд/өрх/-д чиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | | | | | | |
| 221 | Арга хэмжээ 3.3.2.1.1. Аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил, цахим орчныг ашиглан дотоод, гадаад сурталчилгааг сайжруулах зорилгоор “Khentii guide3 гар утасны аппликейшныг олон нийтэд | | Аппликейшн татсан иргэдийн тоо | 2023 онд 58 иргэн | 100-аас дээш иргэгнд аппдикейшн татуулсан байна. | 2024 онд зохион байгуулагдсан Багийн Иргэдийн Нийтийн хуралд оролцсон 226 иргэнд аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил, цахим орчныг ашиглан дотоод, гадаад сурталчилгааг сайжруулах "Khentii guide" гар утасны аппликэйшныг танилцууулж, 84 иргэний гар утсанд тус аппликейшныг | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сурталчлах | | | | | татаж өгөх ажлыг зохион байгуулсан. | |
| 222 | Арга хэмжээ 3.3.2.1.2. Хэнтий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр-2030 хөтөлбөрийн хэрэгжилтийн хангаж ажиллах | | Хэрэгжилтийн хувь | 0 | Хөтөлбөрийн хэрэгжилтийг 50-с дээш хувьд хүргэх | Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр тус суманд гэр буудал, амралтын газар, зочид буудал зоогийн газар ажиллуулах иргэдийн судалгаа холбогдох газарт хүргүүлсэн. Төв магистрал зам дагуу гэр гуанзыг 4 иргэн ажиллуулсан. 2022 оноос эхлэн иргэдийн аюулгүй цэвэр орчинд худалдаа, үйлчилгээ үзүүлэх 240 өртөө ажиллаж 10 иргэнийг байнгын ажлын байраар хангаад байна. Хэнтий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр-2030 хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтийг 40 хувьтай дүгнүүлсэн. | 80 |
| 223 | Зорилт 3.3.2.3. Уламжлалт өв соёл, нутаг орноо сурталчилсан эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулна. | | | | | | |
| 224 | Арга хэмжээ 3.3.2.3.1. Аялал жуулчлалыг татах зорилгоор сум орноо сурталчилсан арга хэмжээ зохион байгуулна. | | Арга хэмжээний тоо | 0 | 1 арга хэмжээ | НАМРЫН БАЯР-2024" нэгдсэн арга хэмжээний үеэр сум сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулагдаж, сумынхаа сурталчилгааны гэрийг барьж, арга хэмжээнд оролцохоор ирсэн үйлдвэрлэгчид болон Чингис хотын иргэдэд орон нутаг судлах танхимын виртуаль музейг сонирхуулж, Соёлын төвийн уран бүтээлчид урлагийн тоглолт толилуулж, сум орон нутгаа сурталчилж, аялал жуулчлалыг татах арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. | 100 |
| 225 | Зорилт 3.3.2.4. Хаягжуулалтын мэдээллийн нэгдсэн системийг бий болгож улсын болон орон нутгийн чанартай авто зам, гудамж талбай, газар нутаг, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулах | | | | | | |
| 226 | Арга хэмжээ 3.3.2.4.1. Эгнээ байрны хаягжуулалтад орсон өөрчлөлтийг хийх | | Нэмэлтээр хаягжуулсан эгнээ хаалганы тоо | 41 барилга, 40 эгнээ | 10-аас доошгүй | Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан " Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам"-ын дагуу MNS 5283:2022 Гудамж, зам, талбай, үл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлагыг хангасан хаягийн тэмдэг суурилуулах ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Хаягжуулалтын ажилд өөрчлөлт хийгдээгүй болно. | |
| 227 | Зорилт 3.3.2.5. Газар зүйн нэрийн тодруулгын ажлыг хийж газар зүйн нэрийн мэдээллийн санг байгуулах, олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах | | | | | | |
| 228 | Арга хэмжээ 3.3.2.5.1. Газар зүйн нэрийн тодруулалт, газар зүйн нэрийн мэдээллийн сан байгуулах ажлыг зохион байгуулах, газар зүйн нэрийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах | | Шинээр болон өөрчлөгдсөн газар зүйн нэрийн хэлэлцсэн тоо | 0 | Шинээр нэмэгдсэн болон өөрчлөгдсөн газар зүйн нэрийг 1-ээс доошгүй удаа газар зүйн нэрийн зөвлөлөөр хэлэлцэнэ | Газар зүйн нэрийн тодруулалтыг хийж, газар зүйн нэрийн мэдээллийн сан байгуулах ажлыг хийж гүйцэтгэх, шинээр нэмэгдсэн болон өөрчлөгдсөн нэрийн саналыг хэлэлцэх талаар сумын Газар зүйн нэрийн салбар зөвлөл 1 удаа хуралдсан. | 100 |
